

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 09 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:

Аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 9 сарын 5, 26-ны өдрүүдэд зохион байгуулж, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу Ховд хотыг ногоон хөгжлийн загвар аймаг болгох үүднээс аймгийн хэмжээнд нийтийн их цэвэрлэгээ хийхээр төлөвлөж, долоо хоног бүрийн Пүрэв гарагийг “Нийтийн их цэвэрлэгээний өдөр” болгохоор захирамж гаргалаа. Нийтийн их цэвэрлэгээний хүрээнд цэвэрч нямбай байгууллага шалгаруулах 5 сая төгрөгийн шагналын сантай болзолт уралдаан зарлаж, долоо хоногийн пүрэв гараг бүр аймгийн бүх албан байгууллагууд нийтээрээ цэвэрлэгээ хийж байна.

Мөн албан газрууд, айл өрхүүдэд 10 сарын 1-нээс халаалт өгөхөөр шийдвэрлэв.

Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн санал авах хэлэлцүүлгийн үйл ажиллагааг сумдад зохион байгуулж, санал асуулгын хуудас тараан явцын тайлан мэдээг авч нэгтгэн товлосон хугацаанд цахимаар, бөглөгдсөн саналын хуудсыг УИХ-ын Тамгын газарт хүргүүлээ.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 31 өргөдөл бичгээр хүлээн авч, 20 өргөдлийг шийдвэрлэж, 11 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт 2 өргөдөл бичгээр хүлээн авч, 2 өргөдлийг шийдвэрлэж, аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 3 өргөдөл бичгээр хүлээн авч шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, нийт өргөдлийн шийдвэрлэлт 61.1 хувьтай байна. Төрийн албаны зөвлөлийн аймгийн салбар зөвлөлд өргөдөл бүртгэгдээгүй болно.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 1 сувгаар дуудлагаар 27 мэдээлэл хүлээн авахад ирүүлснээс гомдол 14, санал хүсэлт 12, шүүмжлэл 1 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 20 иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэж шийдвэрлэлт 74.1 хувьтай байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг “Саналын хайрцагтар өргөдөл хүлээн авах журам”-ын дагуу энэ сард санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 11 санал хүсэлт, 1 талархал хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлэн хариу илгээж, шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 9 дүгээр сарын санхүүжилтийг олгож, цалин хөлс, тогтмол зардал, зарим зайлшгүй гарах зардлуудыг хугацаанд нь санхүүжүүлээ.

Орон нутгийн төсвийн орлогод 4763,6 сая төгрөг орж, төлөвлөгөө 695,0 сая төгрөгөөр буюу 12,7 хувиар, үүнээс татварын орлогод 4332,2 сая төгрөг орж төлөвлөгөө 645,6 мянган төгрөгөөр буюу 12,9 хувиар тасарсан, татварын бус орлогод 431,4 сая төгрөг орж төлөвлөгөө 0,4 сая төгрөгөөр буюу 10,3 хувиар тус тус тасарсан байна.

Орон нутгийн төсвийн зарлага 9 дүгээр сарын байдлаар 37,0 тэрбум төгрөгт хүрч төсөвлөснөөс 3.4 тэрбум төгрөгөөр, үүнээс Орон нутгийн удирдлагыг

хэрэгжүүлэх урсгал зарлага 18938,3 сая төгрөг хүрч, төлөвлөгөөнөөс 350,2 сая төгрөгөөр хэмнэлттэй буюу дутуу гарсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 122.0 сая, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 1560.2 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 259.8 сая, нийт 1942.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээс орон нутгийн хөрөнгө хөрөнгө оруулалт 111.5 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 129.7 сая, ОНХС-аас 1193.4 сая, нийт 1438.6 сая төгрөг олгосон нь төсөвлөснөөс санхүүжилт 503.7 сая төгрөгөөр дутуу байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлийг сар бүр 2017 оны 415-р тушаалын 6-р хавсралт маягтын дагуу Засаг даргаар батлуулан холбогдох яамд болон Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй эрх нь шилжиж ирсэн санхүүжилтыг ажлын гүйцэтгэл, баримтын бүрдлийг шалгаж ЭМС-ын эрх шилжсэн 1185,8 сая, БСШУС-ын 487,6 сая нийт 1673,4 сая төгрөгийг бүрэн олгосон байна.

Сангийн яамнаас ОНХС-ийн 2013-2016 онуудийн системийн бүртгэл хангалтгүй байгаагаас шалтгаалан санхүүжилтийг түр зогсоосон тухай албан бичиг ирсний дагуу сумдад албан бичиг хүргүүлэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч байна.

Төсвийн 40 албан байгууллагаас 560.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрхийн хүсэлт ирснийг Сангийн яамны төрийн сангийн газарт илгээж санхүүжилтын эрхийг нээлгэж гүйлгээг тухай бүр хийлээ.

Энэ сарын байдлаар төрийн сангийн төлбөр тооцооны Freebalance программаар нийт 37 байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 7,8 тэрбум төгрөгийн 1227 ширхэг гүйлгээ хийгдсэн байна. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу төрийн сангийн гүйлгээг түргэн шуурхай гүйцэтгэж байна.

Сангийн яамнаас төрийн сангийн дотоод хяналтын чиглэлээр 2 хүний бүрэлдэхүүнтэй төлөвлөгөөт шалгалт 2017 оны төрийн сангийн үйл ажиллагаанд, мөн Сангийн яамны Эрсдлийн удирдлагын газраас 2 хүний бүрэлдэхүүнтэй шалгалт орон нутгийн болон улсын төсвийн эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сан, бусад сангийн данс, Засаг даргын нөөц хөрөнгө, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, төрийн сангийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд тус тус хяналт, шалгалт хийсэн.

Хяналт, шалгалтаар санхүүгийн үйл ажиллагаа хэвийн түвшинд байна гэж дүгнэж, цаашид анхаарч ажиллах талаар зөрчил арилгуулах талаар зөвлөмж, албан шаардлага өгсөн.

Эдгээр 2 шалгалтын зөвлөмж, албан шаардлага, акт барагдуулах талаар төлөвлөгөө гарган аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 77 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан Засаг даргаар батлуулан ажиллаж байна.

Баруун бүсийн мэргэшсэн нягтлан бодогчид, Санхүү, төрийн сангийн удирдах ажилтнуудын нэгдсэн сургалт, уулзалтыг 09 дүгээр сарын 08-10-нд зохион байгуулж Увс, Говь-Алтай аймгаас 20 гаруй хүн, нийтдээ 80 гаруй нягтлан бодогчид оролцсон.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 30 байгууллагад шалгалт хийхээр төлөвлөсөнөөс 22 байгууллагад төлөвлөгөөт шалгалтыг, 3 байгууллагад гомдол хүсэлтээр тус тус шалгалт хийсэн байна.

Шалгалтаар нийт 390,1 сая төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр акт тогтоож, үндсэн баримтгүй зарцуулсан болон данс бүртгэлд тусгаагүй, хугацаатай сэлбэг хэрэгсэл олгохдоо норм тооцож тооцоо бодоогүй, ур чадвар, үр дүнгийн урамшуулалт цалинг хавтгайруулж, жолоочийн тооцоо бодоогүй, замын хуудас хөтлөөгүй, төсвийн хөрөнгөөр цайллага дайллага зохион байгуулж үрэлгэн зардал гаргасан, орлогын тооцоо бодоогүй, дутагдуулсан зэрэг зөрчлүүд нийтлэг гарч байна.

Статистикийн ерөнхий газраас 2 хүний бүрэлдэхүүнтэй шалгалт Статистикийн хэлтэст 7 хоног ажиллаж, тус хэлтэс сайн дүнтэй шалгагдсан.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд:

Хэлтсийн хурлыг 2 удаа хийж, 3 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 1 иргэнд анхан шатны бичиг баримт боловсруулж, тусламж үзүүлэв.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нотлох баримт ирүүлэх хүсэлт ирсэний дагуу 3 хариу бичиг, нотлох баримтын хамт хүргүүлсэн.

Архивын тасаг нь 6 хөмрөг, 82 хадгаламжийн нэгжийн 1966-1983, 1990-1992, 1981-1990, 1973-1994, 1995-2002, 1981-1991 онуудын 3684 хуудас баримтыг цахим хэлбэрт оруулсан. Лавлагаа авахыг хүссэн 34 иргэнд лавлагаа олголоо.

Цагдаагийн газар: 09 дүгээр сард дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ.

Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Тамхины хяналт” арга хэмжээг зохион байгуулж, төлөвлөгөөний дагуу 82 аж ахуйн нэгж байгууллагыг албан хаагч бүрт хуваарилан өгч, яриа таниулга хийж, тамхины хор хөнөөлөөс ангижирах талаар зөвлөмж тарааж, тамхины цэг байгуулахыг зөвлөв. Зөвшөөрлийн бус цэгт тамхи татаж байсан 12 иргэнийг хуулийн дагуу тус бүр 50.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа.

Ерөнхий боловсролын сургуулиудын захиралтай “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, гэрээний дагуу 1 дүгээр сургуулийн 180 эцэг, эхэд хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдруулах, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулав.

Мөн залуучуудын хөгжлийн төвтэй хамтран 7 сургуулийн ахлах ангийн 1380 сурагчид яриа таниулга хийж харилцан санал солилцлоо.

АА төвтэй хамтран архины хамааралтай 21, баривчлагдсан 7 хүнд архины хор хөнөөлийн талаар яриа таниулга хийж зөвлөмж тарааж өгөв.

Цахим шуудангийн луйврын гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, хүүхдийг зам тээврийн ослоос сэргийлэх, гол усны усны аюулаас сэрэмжлэх, халаасны хулгай, ахуйн хэрэглээний газаас сэргийлэх, архи, тамхины хор хөнөөлөөс сэрэмжлэх талаар мэдээллийг цахим сүлжээнд нийтлэн олон нийтэд хүргэсэн.

Аймгийн хэмжээнд 09 дүгээр сарын 25-ны байдлаар 33 гэмт хэрэг бүртгэгдсэн. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: хулгайлах 8, үүнээс малын хулгай 1, иргэдийн өмчийн хулгай 7, залилах 2, хөрөнгө завших 1, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэрэг 1, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 9, бусдыг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 1, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 5, бусад 5 гэмт хэрэг тус тус бүртгэгдлээ.

Цагдаагийн газраас 09 дүгээр сарын 25-ны байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 297 гомдол мэдээлэл хүлээн авсны гэмт хэрэг 37 буюу 12.0 хувийг гэмт хэргийн талаарх, 260 буюу 88.0 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байгаа бөгөөд зөрчил гаргасан 116 хүнийг албадан саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, жижгээр танхайрсан 19 иргэнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж, 61 жолоочийн

тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, зөрчил гаргасан 1079 хүнийг 39.921.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа

Шүүхийн шинжилгээний алба

Шүүхийн шинжилгээний албанд хандаж 18 албан бичиг, 69 шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж ирүүлснийг хүлээн авч бүртгэн цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 23 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 6 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 63 хүнд, химийн 18, биологийн 10, криминалистикийн шинжилгээ 3 тус тус хийж, нийт 100 дүгнэлт гаргаж, алсын дуудлаганд криминалистикийн шинжээч, шинжээч эмч, туслах ажилтан нар 3 удаа явж үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлэв.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 40 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 1 ширхэг мөр, гутлын мөр 8, тээврийн хэрэгслийн мөр 20, бусад ул мөр, эд мөрийн баримт 21 илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 5, гарын мөр 1 тус тус авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийв. Криминалистикийн шинжээч нар гэрэл зургийн ажил 451 хийснээс шинжилгээний 15, хэргийн газрын үзлэгийн 215, цогцосны үзлэг задлан шинжилгээний 173, бусад 48 тус тус хийж, цагдаагийн байгууллагад хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтэс: Энэ сард нийт 2955 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 2226, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 612 ба шилжин ирсэн иргэд 84, шилжин явсан иргэд 51 иргэн, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 477, гадаад паспорт олголт болон сунгалт 289, иргэний үнэмлэх шинээр олгосон 136, сунгалт 197, дахин олгосон 173, иргэний бүртгэлийн лавлагаа 421 олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 398 бүртгэлийг хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 684, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 45 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажилласан.

Иргэдээс нийт 8 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: Тус газар нь нийт 64 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас 2017 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар, дэд бөгөөд гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт хариуцсан дарга 1, ахлах нийгмийн ажилтан 1, хянагч 1 нийт 3 албан хаагч томилогдоогүй 61 алба хаагчтай ажиллаж байна.

Тус газрын шинээр баригдаж буй Цагдан хорих байр болон конторын барилгын ажил эхэлсэнтэй холбогдуулан бусдад төлөх өр төлбөртэй нэр бүхий 13 хоригдлыг барилгын туслах ажилтнаар ажиллуулах гэрээ байгуулан ажиллуулсан. Барилгын ажил дуусах шатандаа явж байгаа бөгөөд улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна..

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсрол, соёлын чиглэлээр: Тогтвортой хөгжлийг дэмжигч эко сургуулийн тоог нэмэгдүүлэх, аймгийн “Ногоон хөгжлийн хөтөлбөрийг” дэмжих хэрэгцээгээр олон улсын эко сургууль хөтөлбөрийн сүлжээнд шинээр элсэж буй сургуулиудын багш, сурагчид болон сургуулийн удирдлагад зориулсан 2-р шатны сургалтыг Байгаль орчин сургалт мэдээллийн төвтэй хамтран 2 өдөр зохион байгуулж, Цаст-Алтай, Прогресс, Жаргалант-7, Цэцэг сумын сургуулийн 45 багш удирдлага, сурагч хамрагдлаа.

Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 3 дугаар шатанд шалгарсан 18 сургуулиудын төслийн 80 хувийн 106551200 төгрөгийг санхүүжилтийг шилжүүлэн

үйл ажиллагааг эхлүүлж. тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулан хүргүүлэв.

STEM сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглан сургалт явуулах багш бэлтгэх сургалтыг сургууль бүр дээр зохион байгуулж, сургалтад бага ангийн 200 багш хамрагдлаа. STEM сургалтын I-Ү ангийн 520 багц 129 сая төгрөгийн хэрэглэгдэхүүнийг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж сурагчдад хэрэглүүлж эхлээд байна.

I-Ү ангийн 26 төрлийн 16093 ширхэг сурах бичгийн хуваарь гаргаж Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулж сургуулиудаас дутагдалтай сурах бичгийн захиалга авч нэмэлт захиалгаар 5984 ширхэг сурах бичгийг сургуулиудад хүргүүллээ. Мөн бага ангийн 33 төрлийн 236 ширхэг, дунд, ахлах ангийн 15 төрлийн 112 багшийн номыг сургуулиудад хүргүүлсэн байна.

Сургуулийн сурагчдыг сурах бичгээр хангах үйл ажиллагааны хүрээнд 1-5 дугаар ангийн 2456 ширхэг сурах бичгийг дахин хуваарилж сургууль бүрд хүргүүлэв.

Энэ хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 254 хүүхэд суралцаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 6 эцэг эхэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

Аймгийн Боловсрол соёл урлагийн газраас Гүүд нэйборс олон улсын байгууллагатай хамтран “Хүүхэд хамгаалал, Хүүхдийн дасан зохицолд” сэдвээр цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчдийн 90 хүний сургалтыг 9 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулав.

2017-2018 оны хичээлийн жилийн цэцэрлэгийн статистик тоон мэдээг "Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн систем"-д оруулах болсонтой холбоотойгоор 9 дүгээр сарын 20-22-нд Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яамнаас төрийн өмчийн 31 цэцэрлэг, хувийн өмчийн 12 цэцэрлэг нийт 43 цэцэрлэгийн эрхлэгч нарт сургалт амжилттай зохион байгууллаа.

Иргэн төслийн шалгаруулалтад манай аймгийн 10 сургууль хүсэлт хүргүүлснээс Жаргалант сумын 1, 2, 6, 7 Цаст-алтай цогцолбор сургууль, Насан туршийн боловсрол төв, Алтай, Чандмань, Эрдэнэбүрэн, Үенч сумдын сургууль шалгарсан.

Урьдчилсан байдлаар ерөнхий боловсролын 25 сургуульд 17273 хүүхэд 1031 багш, бусад 643 ажиллагсад, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 6718 хүүхэд өдрөөр 1009 хүүхэд хувилбарт сургалтаар 250 бүлэгт суралцаж байна. Бүлгийн 209, бүлэг, хөгжим, туслах багш нийт 422, бусад 366 ажиллагсад ажиллаж байна.

Бүгд найрамдах Солонгос улсын соёлын яам, “Баярлалаа-Бяцхан номын сан” хөтөлбөрийн хүрээнд нээгдсэн “Баярлалаа-Бяцхан номын сан”-ийн нээлт 9 дүгээр сарын 16-ны өдөр Жаргалант сумын 7 дугаар сургууль дээр зохион байгуулагдсан.

Академич, доктор, профессор А.Мекейн нэрэмжит “Баруун бүсийн математикийн олимпад”-ыг 9 дүгээр сарын 23-нд зохион байгуулагдаж, нийт 207 сурагч оюун ухаанаа уралдуулан өрсөлдлөө.

Америкийн нэгдсэн улсын Элчин Сайдын Яамны тэтгэлгээр хэрэгжүүлж байгаа “Аксесс” хөтөлбөрийн элсэлт-д 68 хүүхдийн материал ирснээс 47 хүүхэд 2 дугаар шатанд тэнцээд байна.

Буянт суманд 9 сарын 23-24-ний өдрүүдэд Мянгад, Дөргөн, Жаргалант сумын 7,8, 14 –р цэцэрлэгийн багш нарын “Сургалтын орчин, хамтдаа суралцаж” өдөрлөг сургалт болж, 60 гаруй багш оролцлоо.

Жаргалант сумын “Цаст-Хайрханы бэл” ХХК-ний дэргэдэх “Амин-Эрдэнэ” цэцэрлэгт сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа эрхлэх хүсэлт ирүүлсний дагуу Боловсрол, соёл, урлагийн газрын даргын тушаалаар

байгуулагдсан ажлын хэсэг ажиллан бэлтгэл байдалтай танилцан дүгнэлт гаргаж, шаардлага хангасан тул тусгай зөвшөөрлийн захирамжийг Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яаманд уламжиллаа.

Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын яамны сайдын 2017 оны 1а/8372 дугаар "Багшийн цалин хөлсний шинэчлэлийн тухай" удирдамжийн дагуу нээлттэй хэлэлцүүлгийг сургууль, цэцэрлэгүүд дээр зохион байгуулж, нэгдсэн санал дүгнэлтийг нэгтгэн хүргүүллээ.

Жаргалант сумын 2, 3, 6, Алтай, Дарви, Дөргөн, Дуут, Зэрэг, Манхан, Мянгад, Мөст, Мөнххайрхан, Чандмань, Үенч, Цэцэг, Булган сумын 1, Минжит булган цогцолбор сургуулиудын захирал, Ховд, Чандмань, Үенч, Жаргалант сумын 4, 5, 9, 12, 14, 15 дугаар цэцэрлэгүүдийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг 9 дүгээр сарын 7-ны өдөр журмын дагуу зохион байгуулж, нэгтгэл дүн мэдээг аймгийн төрийн албаны салбар зөвлөлд хүргүүллээ.

Сонгон шалгаруулалтад нийт 17 сургууль, 6 цэцэрлэгийн ажлын байранд 33 хүн оролцож, эхний шатны хуулийн шалгалтад 19 шалгуулагч тэнцсэнээс ярилцлагад орж 1 шалгуулагч тэнцээгүй тул нийт 18 тэнцсэн шалгуулагчийн талаарх мэдээллийг төрийн албаны зөвлөлд уламжиллаа.

Соёл урлагийн чиглэлээр: Аймгийн соёлын ажилтны өдрийг Буянт суманд 09 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулж, 12 сумын 70 гаруй соёлын ажилчид оролцов.

Нийтийн номын сан нь 9 дүгээр сард 273 ширхэг шинэ номоор фонд баяжилт хийж, 418 байнгын уншигч карт нээж, 2949 ирцэд, 4489 ном сонин сэтгүүл олгож үйлчиллээ. "Номын баяр -2017" арга хэмжээг хүүхэд багачууд, уншигчдыг номонд дурлуулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготой "Ном таны оюуны талх" сэдэвт ном уншлагын 7 хоногийн аян 09 дүгээр сарын 14-21-ний хооронд зарлаж, зохион байгуулав.

Америк мэдээллийн төв Америкт суралцах 5 алхмын талаар Улаанбаатар хотын Боловсролын зөвлөгөө өгөх төвийн мэргэжилтэн Одмаа ирж лекц уншиж, Ховд их сургуулийн 350 гаруй оюутнууд дунд сургуулийн 1300 гаруй сурагчдыг хамрууллаа.

Англи хэлний ярианы клуб нь Энхтайвны корпусын сайн дурын ажилтнуудтай хамтран Volunteer club байгуулж оюутан сурагчдын идэвхийг өрнүүлэх сайн дурын ажил аяныг байнга тогтмол зохион байгуулж байна.

"Номын санчдад тавигдах шаардлага" сэдвийн дор цахим уулзалт хийж, Нийтийн номын сан, Ерөнхий боловсролын сургуулиуд, Ховд их сургуулийн номын санчид оролцов.

Аймгийн соёлын төвийн захирал номын санчдад аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтыг зохион байгуулав.

Төрийн Шагналт Ардын Жүжигчин Ж.Чулууны нэрэмжит Алтан гадас одонт Хөгжимт Драмын Театр нь 2017 оны Өвөл цагийн соёл хүмүүжлийн ажлын 80 дахь жилийг тохиолдуулан ахмад уран бүтээлчидтэй хамтран 8 уран бүтээлийг сэргээн туурвих ажлыг зохион байгуулах ажлын комисс байгуулагдаж, гүйцэтгэл 30 хувьтай явагдаж байна. 09 дүгээр сарын байдлаар 10 үйл ажиллагаанд, нийт 3700 үзэгчдэд соёл урлагийн үйлчилгээг үзүүллээ.

Аймгийн Музей нь Ховд сумын Хавцгайтын Дэрстийн хөтлөөс авран хамгаалсан хадны зургуудыг Өв соёлын хүрээлэнд байрлуулах ажлыг "НКВ international holding" ХХК-тай хамтран гүйцэтгэж байна. Энэхүү ажлын үр дүнд түүх, соёлын дурсгалыг устах аюулаас хамгаалж, хадгалалт хамгаалалтыг нь сайжруулсан.

Эрүүл мэндийн чиглэлээр: “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа хепатит С, В вирусийн илрүүлэг шинжилгээний мэдээг 7 хоног бүр 16 сум, 6 өрх, Бүсийн оношлогоо эмчилгээний төвөөс авч нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлж ажиллалаа. 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд илрүүлэг шинжилгээнд 9434 хүн хамрагдаж хамралтын хувь 51,7%-тай байна. Үүнээс эрүүл мэндийн даатгалгүй 652 иргэн хамрагдсан байна. Илрүүлэг шинжилгээнд хамрагдсан иргэдийн 909 нь хепатит В вирусын халдвартай, 1306 нь хепатит С вирусын халдвартай, хепатит В,С вирусын халдвартай 93, эрүүл 7128 хүн байна. Одоогийн байдлаар Эрдэнэбүрэн сум 102,8 хувьтай /өөр сумын иргэд хамрагдсан/ хамрагдаж дуусаад байна. Элэгний С вирус илэрсэн 1286 хүнээс вирусын идэвхжил тодорхойлох шинжилгээнд 699 хүн хамрагдаж, хамралт 54,5 хувьтай байна. Элэгний С вирусын идэвхжил тодорхойлсон иргэдээс эмчилгээнд 101 хамрагдаж, идэвхжилгүй болсон 6 иргэн, 20 хүн эмчилгээнийхээ 3 дахь тунг тус тус ууж байна.

7 хоног тутмын халдварт өвчний эргэн мэдээллийг бэлтгэн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, 16 сумын эрүүл мэндийн төв, 6 өрхийн эрүүл мэндийн төв, аймгийн Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын газрууд хүргүүлэн ажиллалаа.

2017 - 2018 оны томуугийн улирлын үед 0-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдыг вакцинжуулахаар шийдвэрлэлээ.

Тарваган тахлын хүний өвчлөлийн дуудлага 8 дугаар сарын 24-нд ирж, аймгийн ЭМГ-ын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн голомтонд 5 хоног ажиллаж, мэргэжил арга зүйгээр хангалаа. Сэжигтэй дуудлага ирснээс хойш нэгдүгээр хавьтлын 7 хүнийг 6 цагийн дотор, нэгдүгээр хавьтлын 2 хүнийг 48 цагийн дотор, нэгдүгээр хавьтлын 3 хүнийг 72 цагийн дотор тус тус илрүүлэн тусгаарлан, хөл хорионы арга хэмжээг авч урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулсан. Халдварын эх уурхай нь Хар тарвага, Баян-Өлгий аймаг, Дэлүүн сумын Улаагчийн даваанаас агнаж авч ирсэн болох нь тогтоогдсон. Сэжигтэй дуудлага Жаргалант сумаас хүний өвчлөлийн сэжигтэй дуудлага Бичигт багаас-1, Наран баг-2, Буянт баг-3, Цамбагарав-1, Баатархайрхан-1, Цамбагарав-1, нийт 9 дуудлага ирж эмнэлзүй, тархвар судлалаар үгүйсгэгдсэн. “Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай” сургалтыг 09 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулж, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн Өрхийн эрүүл мэндийн төвүүд, сумын эрүүл мэндийн төвүүдийн эрхлэгч эмч, голомт хяналтын эмч нар оролцсон.

“Клиникийн эмнэлгүүдийн халдварын сэргийлэлт, хяналт” сэдэвт салбарын сургалтыг 09 дүгээр сарын 21-ний өдөр аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран зохион байгуулж, аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй шүдний 6 эмнэлгийн эмч, ажилчид хамрагдлаа.

Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн аймаг дахь салбартай хамтран сүрьеэ өвчнөөр өвдөх эрсдэлтэй бүлгийн хүн амын судалгааг гарган, тандалт хийж, сэжигтэй тохиолдлуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар 5 өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран үзлэгт Жаргалант сумын иргэдийг хамруулан ажиллаж байна.

8 дугаар сарын товлолын дархлаажуулалтанд 0-2 насны хүүхдүүд сүрьеэгийн эсрэг вакцин болон В гепатитын эсрэг вакцинд 99%-тай, халдварт саагийн эсрэг вакцинд 99,2%-тай, тавт вакцинд /сахуу-хөхүүл ханиад-татран- В вируст хепатит-хемофилюс инфлюэнза В/ 99,3%-тай, улаанбурхан-гахайн хавдар-улаануудаас сэргийлэх 3т вакцинд 100 %-тай, А вируст хепатитаас сэргийлэх вакцинд 99,7%-тай хамрагдаж, тарилгатай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж ажилласан. Нийтдээ 8 сарын дархлаажуулалтын хамралт 99,4% тай хийгдлээ. Улаанбурхан, гахайн

хавдар, улаануудаас сэргийлэх вакцины эхний тунд 10 сартай 1 хүүхэд, А вируст хепатитаас сэргийлэх вакцины мөн эхний тунд 1,3 сартай хүүхдийг тус тус нөхөн дархлаажуулалтанд хамруулсан. Вакцин задалснаас хойш хүн ирээгүй шалтгаанаар нийтдээ 1004 хүн тун вакцин хорогдсон.

4 дүгээр улиралд хэрэглэгдэх 7 нэр төрлийн 35,797, 718.25 төгрөгийн үнэ бүхий вакцин, биобэлдмэлийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албанаас захиалан авч дархлаажуулалт бүхий цэгүүдэд хүргүүлэхэд бэлэн болсон. Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн амаржих газар, сүрьеэгийн тасаг, Булганы нэгдсэн эмнэлэг, Чандмань, Мөнххайрхан, Цэцэг, Зэрэг, Ховд сумын эрүүл мэндийн төвүүд, Рашаант, Бугат, Буянт, Баатархайрхан, Жаргалан өрхийн эрүүл мэндийн төвүүдэд вакцин, түүнийг дагалдах хэрэгслийг хуваарилан хүргүүллээ.

Тархвар судлалын заалтаар нохойд уруулж ноцуулсан 7 хүнийг галзуу өвчнөөс сэргийлэх вакцин, үүн дотроо 2 хүнийг ийлдэс эмчилгээнд хамруулж галзуу өвчнөөс урьдчилан сэргийлж ажилласан.

9 дүгээр сард нийтдээ 4 удаа ТТӨ, халдварт өвчний хам шинж, сэжигтэй өвөрмөц тохиолдлын холбогдох газруудад цаг хугацаанд нь мэдээлж, оновчтой хариу арга хэмжээг авч ажилласан.

Аймгийн хэмжээнд 4567 хүн амбулаториор үйлчлүүлсэний 178 нь томуу, томуу төст гэж оношлогдон үүнээс 19 нь уушгины хатгаагаар хүндрэн эмнэлэгт хэвтсэн. Түргэн тусламжийн 174 дуудлагаас 22 нь томуугийн дуудлага эзэлж байна.

Амбулаторт эзлэх томуугийн хувь 3,8-тай бүртэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,8 %-иар их байна. 9 дүгээр сард нийт 4 салхинцэцэг бүртгэгдсэн ба өвчлөл харьцангуй бага байна. Мөн тарилгатай халдварт өвчин болоод дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн мэдээг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн facebook хаягаар 4 удаа тасралтгүй цаг хугацаанд нь мэдээлж ажилласан. Энэ сард дархлаажуулалтын дараахь хүнд, хүндэвтэр урвал хүндрэл болон тарилгатай халдварт өвчин бүртгэгдээгүй.

2017-2018 оны улирлын томуугийн дархлаажуулалтанд хамрагдах эрсдэлт бүлгийн хүн амын тоог Бүсийн оношлогоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн Томуугийн үндэсний төвд хүргүүлсэн.

Хавдар судлалын үндэсний төв, тус ТББ-ын бүх талын дэмжлэгтэйгээр 09 сарын 07-18-ны өдрүүдэд Зэрэг, Мөст, Үенч, Цэцэг, Алтай, Мөст, Булган, Мөнххайрхан сумдын 750 гаруй эмэгтэйчүүдэд газар дээр нь эмэгтэйчүүдийн хавдрын урьдчилан сэргийлэх үзлэг хийлээ.

Эхний 8 сарын байдлаар Булган сумын нэгдсэн эмнэлэг 36,4 сая, Мөст сумын сум дундын эмнэлэг 5,1 сая, сумдын эрүүл мэндийн төвүүд 61,5 сая төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд нийт 103,0 сая төгрөгийн өглөгтэй байна.

“Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо, шинжилгээний багц”-ыг хийх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах шалгаруулалтанд 6 байгууллага материалаа ирүүлсэнээс Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Ач заяа, Мөнхцохилохуй зэрэг 3 эрүүл мэндийн байгууллага шалгарсан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам бусад холбогдох байгууллагуудаас хамтран зохион байгуулж буй “Хууль бус үр хөндөлтийг бууруулах” аяны хүрээнд иргэдэд “Үр хөндөлт бол жирэмслэлтээс сэргийлэх арга биш” гэдэг мессэжийг өгч ажиллалаа.

Иргэдийн дунд БЗДХ, тэр дундаа төрөлхийн тэмбүү өвчин нэмэгдэх хандлагатай байгаатай холбогдуулан Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд охид хөвгүүдийн урьдчилан

сэргийлэх үзлэгийг Бүсийн оношлогоо эмчилгээний төв, өрх болон сургуулийн эмч нартай хамтран зохион байгуулж эхлээд байна.

“Хүүхдийн хараа хамгаалах өдөр”-ийг үндэсний хэмжээнд тэмдэглэх нэгдсэн удирдамжийн тайланг бичиж Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт хүргүүлэв.

Дэлхийн эм зүйчдийн өдрийг тохиолдуулан аймгийн Эрүүл мэндийн газраас санаачлан, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Эм холбоотой хамтран 9 дүгээр сарын 25-аас 11 дүгээр сарын 25-ны хооронд “Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлье” 2 сарын аян зарлан, эмч, эмийн мэргэжилтэн, иргэдэд чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тандалт судалгааны албанд 35, 36, 37 дахь 7 хоног бүрийн мэдээг Эрүүл мэндийн 23 байгууллагаас авч нэгтгэн мэдээллээ. 2012, 2013, 2014, 2015, 2016 оны 8 сарын мэдээг 24-н Эрүүл мэндийн байгууллагуудаас авч тулган, эхний 8 сарын байдлаар H-info программд тулгалт хийж, зөрсөн мэдээ баазыг засав.

1454 эх амаржиж 1467 хүүхэд амьд төрсөн ба амьд төрсөн хүүхдийн 4,2 хувийг 2500 гр- аас доош жинтэй хүүхэд эзэлж байна. Жирэмсний эхний 3 сартай хяналт 89,3 хувь байна. 280 нас баралт бүртгэгдсэнээс 60.3 хувь нь эмэгтэй, 39.7 хувь нь эрэгтэй байна. 0- 1 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 28 буюу 1000 амьд төрөлтөнд 19 промилль байна. 0-5 хүртэлх насны 33 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөнд 22,5 промилль байна.

9 дүгээр сарын байдлаар 358 халдварт өвчин бүртгэгдэж 10000 хүн амд 41,7 процедицимилль байгаа бөгөөд бүтцээр нь авч үзвэл 6,9 хувийг сүрьеэ, 17 хувийг салхин цэцэг, 21,5 хувийг тэмбүү өвчин, 16,2 хувийг трихомониаз өвчин, 3,6 хувийн Гонококкт халдварт өвчин тус тус эзэлж байна.

Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон 16 сумын эрүүл мэндийн төвүүдэд хэрэглэгдэх 26 нэр төрлийн эмийн тоо хэмжээний талаарх тооцоо судалгааг авч нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд 2017 оны эмнэлгийн тусламж үйлчилгээнд тасарсан эм, эмнэлгийн хэрэгслийн судалгааг гарган Эрүүл мэндийн яамны Эм үйлдвэрлэл, технологийн газарт хүргүүллээ.

Сумдын эрүүл мэндийн төвүүдийн амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалт 80%, сумын дундын эмнэлэг 86%, сумын нэгдсэн эмнэлэг 94%, Бүсийн оношлогоо эмчилгээний төв 96, аймгийн хэмжээнд амин чухал эм эмнэлгийн хэрэгслийн хангалт 89 хувьтай байна. Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 129/100 дугаар тушаалын 1.9-д заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төлбөрийг нь төр хариуцах эмийн тайланг 2017 оны хагас жилийн байдлаар гаргуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эм, эмнэлгийн хэрэгслийн албанд, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэн шаардлагатай эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжүүдийг шийдэж өгөх талаар албан тоотыг тоног төхөөрөмжийн судалгааны хамт Эрүүл мэндийн яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газарт, 2018 оны төсвийн төсөлд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээг Өрх сум, тосгоны Эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт үзүүлэхэд шаардлагатай тооцоо хийгдэж байгаатай холбоотой 2018 оноос Өрх, сумын эрүүл мэндийн төвд олгох санхүүжилтийн хэмжээг тодорхойлох судалгааны дагуу 14 сумын эрүүл мэндийн төв, 1 сум дундын эмнэлэг, 6 өрхийн эрүүл мэндийн төвөөс авч нэгтгэн Эрүүл мэндийн яаманд тус тус хүргүүлсэн.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 2016 онд магадлан итгэмжлэлд орсон эрүүл мэндийн байгууллагуудын Чанарын хөгжлийн хөтөлбөр засварлагдан буцаж ирсэн тул засварын дагуу яаралтай засан ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн. 2017 онд Магадлан итгэмжлэлд орох сумдын маршрутыг хийн Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.

Аймагт ажиллаж буй сувилагч, тусгай мэргэжилтний судалгааг авч нэгтгэсэн.

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, нэгдсэн эмнэлгийг сувилахуйн албадын дарга нарын цахим хурлын хуваарийн дагуу 09 сарын 06, 19-ний өдрийн цахим хуралд оролцож хэлэлцсэн асуудалд санал өгсөн.

ORS, цайр бичил тэжээлийг сумын нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдэд хуваарь хийж, хуваарийн дагуу тарааж байна.

Хүүхдийн зуны чийрэгжүүлэх сувилалын тайланг өрх, сумын эрүүл мэндийн төвүүдээс хүлээн авлаа.

Биеийн тамир спортын чиглэлээр: Биеийг тамир спортын газрын 2017 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна.

9 дүгээр сарын 08-10-ны өдрүүдэд Биеийн тамир спортын газрын түүхт 70 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлж, Баярын хурал болон үндэсний спортын 3 төрлөөр /Үндэсний бөх, Сурын харваа, Хурдан морь/ уралдаан тэмцээн зохион байгуулав.

09 дүгээр сарын 13-нд Ширээний теннисний спортын мастер Цагаачийн нэрэмжит Олон хотын аварга шалгаруулах тэмцээн 2 насны ангилалаар зохион байгуулагдаж Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Оросын холбооны улс, Казакстан, Солонгос улсын 100 гаруй, 09 дугаар сарын 14-21 хооронд шатрын баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээн, "Open-2017" нээлттэй тэмцээн болж Улаанбаатар хотоос 5 их мастер, улсын аварга тамирчид ирж оролцож мөн Говь-Алтай, Баян-өлгий, Ховд, Увс, Завхан, Өмнөговь аймгуудын 100 гаруй тамирчид оролцов.

09 дүгээр сарын 20-ны өдөр Үндэсний бөхийн Өсвөр Идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах барилдаан, Баруун бүсийн мэргэжлийн боловсролын их дээд сургууль, коллежийн оюутны Универсиад-2017 урлаг спортын уламжлалт их наадмыг хамтран амжилттай зохион байгууллаа.

Хүүхэд, гэр бүл, залуучуудын чиглэлээр: "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлсэн тайлан судалгааны асуумжийг бөглөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүллээ.

Цахим тоглоомд насанд хүрээгүй хүүхэд хэт хамааралтай болж донтох гэмт хэрэгт холбогдох ихэсэж байгаа өнөө цагт 17 сумдаас судалгаа авч мэдээллийн санг бий болгосон.

Түр хугацаагаар эцэг эхийн асран хамгааллаас хол хөндий айлд амьдарч байгаа хүүхдийн хамгаалагдах эрхийн нөхцөл байдал, эрсдэл, эмзэг байдлыг чанарын мэдээлэлд тулгуурлан тодорхойлж, шийдвэрлэх оновчтой гарц бүхий санал зөвлөмж боловсруулах зорилгоор эдгээр хүүхдийн судалгааг гаргах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж байна.

Аймаг, сумдын соёлын ажилтнуудад зориулсан "Монгол хүн угийн бичиг хөтлөх нэн тулгамдсан шаардлага хэрэгжүүлэх арга зам" сургалтыг зохион байгуулав.

Хүүхдийн оролцооны байгууллагууд, өсвөр үеийн V-peeг клуб, Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх залуучуудын зөвлөлийн нийт 150 залуучууд, өсвөр үеийнтэй уулзаж мэдээлэл хийж харилцан санал бодлоо солилцлоо.

Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр: Улсын төсвөөс нийт 1.812.900.000/төгрөг/-ийн санхүүжилт авснаас Алдарт эхийн одонд-

1.230.000.000, Алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд-75.000.000, Ахмадын “Насны хишиг”-д- 506.000.000 санхүүжилтийг тус тус зарцуулагдсан байна.

Орон нутгийн төсвөөс 4.267.000.000 төгрөгийн санхүүжилт авч халамжийн сангийн үйл ажиллагааг хэвийн явж байна.

09 дүгээр сард хүнсний эрхийн бичгийн цаасан болон цахим хэлбэрээр үйлчилгээ авдаг 806 өрхөд /том хүн 2708, хүүхэд 2356/ 50518000 төгрөгийн үйлчилгээ үзүүлэхээр хүлээгдэж байна. Хүнсний цаасан эрхийн бичиг 7, 8 сарын хүнсний талон ирсэнийг ялгаж сумдад хүргүүлэв.

ХХҮГ- тай шинээр гэрээ байгуулсан орон нутгийн “Нэвт” амралт, сувилалд 30 ахмад, “Эвт урлал” амралт сувилалд 25 ахмад, Цагаан уул амралт сувилалд 33 ахмад амруулсан. Орон нутгийн амралт сувилалд нийт 88 ахмад амарч сувилуулаад байна. Улаанбаатар хотын дүүргүүдийн амралт сувилалд амрахаар 2 ахмад настан эрхийн бичиг авсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс хуралдаж хөгжлийн бэрхшээлтэй 13 хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тохирох үйлчилгээнд хамрууллаа. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд халамжийн сангаас Ортопедийн тусгай хэрэгсэл авсан эсхийг программд шалгаж, үйлчилгээ авах эрх үүссэн 23 иргэний бичиг баримтыг хүлээн авч ортопедийн туслах хэрэгсэл олгож waic программд бүртгэлээ.

Тайлант сард нийт 66 ажил идэвхитэй хайгч иргэнийг шинээр бүртгэж, 250 иргэний мэдээллийг шинэчлэн, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд идэвхижүүлээ. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд бүртгэлтэй ажилгүй иргэд 1825 үүнээс эмэгтэй 984 байна. Ажил идэвхитэй хайгчдаас 953 иргэнийг ажлын байранд зуучлан оруулсан байна. Шинээр бий болсон 495 ажлын байрыг бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн LMIS санд орууллаа. Ажил олгогч аж ахуй нэгж байгууллага иргэдээс 1030 ажлын байрны захиалга авч бүртгэлтэй ажил хайгч иргэдээс 953 үүнээс эмэгтэй 447 иргэн ажилд зуучлагдан орсон байна. Байнгын 555, улирлын 161, түр 237 ажлын байртай болсон байна.

Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр GFA Консалтинг группын хэрэгжүүлж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд туршилтын хөтөлбөрийн гарааны бизнесийг дэмжих сургалт, арга хэмжээг 9 дүгээр сарын 13-15-ны өдрүүдэд Хаймгийн Үенч, Булган, Алтай сумдын 15-34 насны залуучуудын дунд зохион байгуулж шилдэг гарааны бизнесээр “Буйдан үйлдвэрлэгч” залуучууд шалгарч 10,0 сая төгрөг, дэд байрыг Булган сумын Чацаргана хураах тоног төхөөрөмж нөөцлөх хадгалах бизнес санаа шалгаран 6,0 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэгт хамрагдах эрхийн бичиг гардан авсан.

Асруулагчдад стандартын дагуу өдөрт 4 удаа, 7 хоногт 15 нэр төрлийн хоол хүнсээр үйлчилж байна. Асруулагчдыг халуун усанд оруулж, хэвтрийн асруулагчдад өдөр бүр тогтмол мэргэжлийн асаргаа үйлчилгээ үзүүлж ажилладаг. 09 сард асруулагчдын хоол хүнсэнд 1,720,450 төгрөг зарцууллаа.

“Цагаан-Уул” ахмадын сувилалд 9 дүгээр сард 37 ахмад настан амарч сувилууллаа. Эдгээр 359 ор хоногтой амрагчдаас 2872000 төгрөг орлого төвлөрүүлэн ажиллалаа.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр:

Тус хэлтэст 33 албан бичиг хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан бөгөөд 34 албан бичиг тоотыг холбогдох газарт хүргүүлж, 6 өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэгдэх шатандаа явж байна. Даатгуулагч иргэдэд 743 архивын лавлагаа гаргаж өгөв.

Сайн дурын даатгалд 09 дүгээр сард 5383 даатгуулагчийн 845,2 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн. 09 дүгээр сард 9994 даатгуулагчийн 436,3 сая төгрөгийн

эрүүл мэндийн даатгалын орлого төвлөрүүлсэн байна. 739 ажил олгогч 13203 даатгуулагч хамрагдаж, шимтгэлийн орлого 8,954 сая төгрөг төвлөрүүлэх тооцоотой байна.

Эхний 09 дүгээр сарын байдлаар өндөр насны тэтгэвэрт 7530 хүнд 12562591,1 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 1743 хүнд 2103912.2 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 824 хүнд 1065685.2 мянган төгрөг, цэргийн тэтгэвэрт 214 хүнд 614700.7 мянган төгрөг, Үйлдвэрийн ослын тэтгэвэрт 38 хүнд 70992,9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 934 даатгуулагчид, 978842.7 сая төгрөг, Хөдөлмөрийн чадвараа түр алдагчдын тэтгэмжид 582 даатгуулагчид 59393.6 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид 228 даатгуулагчид 300254.4 сая төгрөг, 226 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 226,000,000 төгрөгийг тус тус олгож зарцуулсан.

Эх хүүхдийн магадлах комиссын ээлжит хурлыг 09 дүгээр сард 2 удаа хийж нийтдээ 86 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааны асуудлыг хэлэлцэж 45 иргэний актыг сунгаж, 12 иргэний актыг цуцалж ажилласны гадна 29 иргэний хугацааны актыг шинээр тогтоосон. Энэ сарын байдлаар мэдээллийн баазад 3850 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлтэй байна.

Тав: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:

Мал аж ахуйн талаар: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын санаачилгаар Баруун бүсийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн эмч, мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулагдсан сургалт, урлаг, спортын нэгдсэн арга хэмжээ аймагт 09 сарын 08-10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагд баруун 5 аймгийн ХХААГазрын дарга, албаны дарга, эмч, мэргэжилтэн, сумдын МЭҮТасгийн эмч, мэргэжилтэн нийт 200 орчим хүн хамрагдлаа.

Тус арга хэмжээний үеэр ХХААХҮЯамнаас аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар фургон автомашин, 17 сумын Мал эмнэлэг, үржлийн тасагт мотоцикл гардуулж өглөө.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал эмнэлгийн албанаас “Гоц халдварт өвчний үеийн үзүүлэх сургууль”-г зохион байгуулав.

УИХ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт, УИХ-ын гишүүн О.Батнасан нарын санаачлагаар аймагт “Малчин, Удирдах ажилтнуудын зөвлөгөөн” 09 дүгээр сарын 09-нд зохион байгуулагдаж 270 гаруй хүн оролцлоо.

2017-2018 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах 4 ажлын хэсэг сумдад ажиллаа.

09 сарын 20-ны байдлаар малчдын түвшинд 56,9 мянган тн өвс, 304 тн сүрэл, 143,1 тн ногоон тэжээл, 358 тн үйлдвэрийн тэжээл, 2,1 мянган тн гар тэжээл, 5,6 мянган тн хужир шүү бэлтгэсэн дүн мэдээтэй байна. Сумын аюулгүй нөөцөд нийт 561,8 тн өвс, 110 тн тэжээл бэлтгэсэн байна.

Аймгийн аюулгүйн нөөцийн 100 тн өвс, 50тн тэжээлийн авах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Мал эмнэлэгийн талаар:

Бог малын Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг ХХААГ-ын даргын А/25 тоот захирамж гарган 8-р сарын 20-оос 9-р сарын 15-ны хооронд 32,1 мянган толгой тугал, 893,1 мянган толгой хурга ишгэнд хийхээр төлөвлөн 17 сумын 53 МЭҮН-д шаардагдах вакциныг хүргүүлэн 97,0 хувьтай хийгдээд байна.

Хээлтүүлэгч бог малд Бруцеллэз өвчний халдвар байгаа эсэхийг илрүүлэх зорилгоор 10823 толгой малд шинжилгээ хийхэд 49 мал эерэг урвал үзүүлсэн нь нийт шинжилгээнд хамрагдсан малын 0,4 хувь нь уг өвчний халдвартай байна.

Лабораторийн барилгын их засвар хийхэд шаардагдах зардлыг тооцоолон 60000,0 сая төгрөг төсөвлөж холбогдох газруудад хүргүүлж ажилласнаар ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 05-р сарын 01-ний өдрийн А-57 тоот тушаалаар мал эмнэлгийн оношлогоо ариун цэврийн лабораторийн барилгын засварт 35000,0 сая төгрөг

“Хан орд” хүнсний захад худалдаалагдаж байгаа 3614 кг махны 413 дээж, 2000 л сүүний 63 дээж, арьс 100, ноос 1030 МЭАЦ-н шинжилгээ хийж, 2150 м/кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Хүнс, газар тариалан, жижиг дунд үйлдвэрийн талаар: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын мастер тогоочдын холбоотой хамтран “Chinggis khan challenge cup 2017” Монгол үндэстний олон улсын болон хоолны фестиваль, олон улсын тогооч нарын тэмцээнд “Зочин бууз” гуанзны тогооч Б.Цэцэгмаа, , “Заяа дэлгэрэх” ХХК-ий тогооч Г.Наранхүү нар оролцож, мөнгө, хүрэл медаль хүртлээ.

“Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээний “Эрүүл тонгол хүнс-2017” үзэсгэлэн худалдаанд “Оюутогтох” ХХК, “Сүүн Оргил” ХХК цагаан идээ, тарианы гурил, шар тос, айргийн тос, чацарганы жүүс, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнээр оролцлоо.

Байгаль орчны талаар: Байгаль орчин, аялал жуулчлалын газар 9 дүгээр сард нийт 157 албан бичиг хүлээн авч холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. 157 албан бичиг төлөвлөн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Байгууллагын даргын тушаал 3 гарсан байна.

БОАЖГазар, Дэлхийн байгаль хамгаалах сан, Зооноз өвчин судлалын төв хамтран “Цагаан морь” зах дээр тарваган тахал, хууль бус агнуур, ан амьтны эд эрхтний худалдааны талаарх мэдээлэл бүхий сурталчилгааны самбар байршууллаа.

Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн санхүүжилтээр “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв”-өөс 09 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулж, Увс, Баян-Өлгий, Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Сав газрын захиргаа, Ус, цаг уур орчны шинжилгээний газрын ажилтан, албан хаагчид 105 хүн хамрагдаж, гэрчилгээ олголоо.

08 сарын 31-ний А/26 тушаалын дагуу “Ховд Өнөр Бүл” ХХК-д Ховд гол Хар нуурын сав газрын гаргасан дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэлийн хэрэгцээнд 6573 м³ усыг 1 жилийн хугацаанд ашиглах зөвшөөрөл, 2017 оны А/28 тушаалын дагуу “Арслан Бар Хоршоо” ХХК-д Ховд гол Хар нуурын сав газрын гаргасан дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэлийн хэрэгцээнд 13750 м³ усыг 1 жилийн хугацаанд ашиглах зөвшөөрөл олгон тус тус хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Усны тухай хуулийн 27.1 дэх заалтыг үндэслэн иргэн Д.Энхбаярт худаг гаргаж ашиглах зөвшөөрлийг олгосон.

Дарви сумын Баянбулаг багийн нутаг “Ар улаан булаг”-ийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хөв, цөөрөм байгуулж булгийн эхийг, Мөнгөн аяга багийн нутаг “Тахилтын булаг”-ийн эхийг “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” төслийн хөрөнгөөр тохижуулж хамгаалсан.

БОАЖ-ын Сайд, Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу Дарви сумын Дэлгэр багийн “Баян гол”-ын усны эхийг хашиж хамгаалж сайжруулсан.

Аймгийн Тахилт, Алагтолгой, Бугат, Хайрхан, Бичигт, Буянт, Баатархайрхан, Жаргалант багуудын инженерийн хийцтэй 30 худагнаас дээж авч шинжилгээнд хамруулан ажиллаж байна.

Булган сумын Байтаг багийн нутаг “Балжин” нэртэй газар гал гарч сумын албан байгууллага, аж ахуйн нэгж, нутгийн иргэд хамтран шуурхай арга хэмжээ авч галыг бүрэн унтрааж ажиллалаа.

Аялал жуулчлалын талаар: Баруун бүсийн тулгуур төв Ховд аймаг аялал жуулчлалыг хөгжүүлэх үүднээс “Гурван Сэнхэр төвтэй таван од” г дэд хөтөлбөрийн танилцуулга, хэлэлцүүлгийг 09 сарын 03-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газарт зохион байгууллаа.

Орчны бохирдлын талаар: Ногоон хөгжлийн загвар аймаг болох зорилтын хүрээнд “Цэвэрч Ховдчууд” болзолт уралдаан зарлаж, долоо хоног бүрийн Пүрэв гарагийг аймгийн Засаг даргын захирамжаар бүх нийтийн их цэвэрлэгээний өдөр болгосонтой холбоотой 09 дүгээр сарын 07, 14, 21-ний өдрүүдэд нийт 3 удаагийн цэвэрлэгээгээр 81 машин хог буюу 228м/куб хог цэвэрлэсэн байна.

Газар, газрын хэвлий түүний баялгийн хамгаалалт, нөхөн сэргээлт, зохистой ашиглалт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний талаар

Аймгийн Засаг даргын 2017 оны А/348 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 08 дугаар сарын 28-аас 09 дүгээр сарын 10-ны хооронд аймгийн 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан эвдрэл, элэгдэл доройтолд орж хөндөгдсөн газруудыг мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлт хийлгүүлэх ажлыг зохион байгуулж буй талаар болон нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны явцтай танилцах, холбогдох дүгнэлт гаргах зорилгоор Алтай, Булган, Үенч, Мөст, Цэцэг, Дөргөн сумдад хяналт шалгалт хийлээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний талаар: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн дагуу Дарви сумын Булган багийн нутагт дэвсгэрт “Эбон тур” ХХК-ний хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Үйлчилгээний цогцолбор” байгуулах төслийн холбогдох материалтай танилцаж, зөвлөгөө өглөө.

“Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах тайлагнах” журмын дагуу Дөргөн сумын Шаргатын уул хэмээх газарт XV-17739 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Дун гоулд” ХХК-ний 2017 оны “Байгаль орчин хамгаалах менежмент төлөвлөгөө”-г хянаж хүргүүллээ.

Аймгийн нийт нутаг дэвсгэрт ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааг хийхээр мэргэжлийн байгууллага “Уламжлалт ав” ХХК шалгаран сумдын байгаль хамгаалагч нартай хамтран ангийн бүс нутгуудаар явж аргаль, янгирийн тооллого, судалгаа хийж байна.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, ЗООНОЗ өвчин судлалын төв, Хар-Ус нуур орчмын УТХГН-ийн хамгаалалтын захиргаа, Жаргалант сумын ЗДТГ хамтарсан удирдамж гарган ан амьтдын гаралтай бүтээгдэхүүнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 8 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн Цагдаагийн газартай хамтран хууль бус ангийн хяналт шалгалтыг хуваарийн дагуу 08 сарын 31-ээс 09 сарын 14-нийг хүртэл орой 22.00 цагаас, өглөө 10.00 цагийн хооронд Модон овооны чиглэлд хяналтаар ажиллалаа.

Хөрөнгө оруулалтын талаар аймгийн Засаг даргын Тамгын газарт уулзалтын өрөөг тохижуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гэрээг 09 сарын 06-нд хийгээд ажил 09 дүгээр сарын 18-нд хүлээлгэн өгсөн. 09 сарын 11-нд Булган сумын 2 дугаар сургуулийн засварын ажил гүйцэтгэгч “Жаргалант луу” ХХК дунд шатны гүйцэтгэлийн, Дарви сумын сургуулийн дотуур байрны засварын ажлыг гүйцэтгэгч “Буянтын боргио” ХХК-ны ажлын гүйцэтгэлийн, ажлын явцыг дүгнэн

явцын санхүүжилтийн, 09-сарын 22-нд Мөст сумын 12 жилийн сургуулийн 2 дугаар байрны засварын ажлыг гүйцэтгэгч “Ховдын Хаш өргөө” ХХК-ний эцсийн санхүүжилтийн материалуудыг Сангийн яам руу явуулсан. 09 дүгээр сарын 25-ны өдөр Цахим Трейдинг ХХК-ний гэрээний хугацаа дууссан боловч ажлаа гүйцэтгээгүй байна. Эко Буянт ХХК-ний гэрээний хугацаа дууссан компаниас гэрээ сунгаж өгөх хүсэлт ирүүлсэн хүсэлтийн дагуу гэрээг 09-дүгээр сарын 28-ны өдөр сунгаж байгуулав.

Зам тээврийн талаар: Замын сангийн хөрөнгө оруулалтаар Жаргалант суманд 2 км явган замын ажлыг “Зол дайчин” ХХК гүйцэтгэж, байнгын ашиглалтанд хүлээн авав.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант суманд хэсэгчилсэн 3.784 км хатуу хучилттай авто замын барилгын ажил эхлээд байна. Гүйцэтгэгчээр “Түм дэлгэрэх” ХХК ажиллаж байна. Энэ сард Ховд аймагт нисэх буудалд 7 хоногт 8 нислэг үйлдэгдэж байна.

“МоЭнКо” ХХК, аймагтай хамтран ажиллах гэрээг үзэглэсэн ба гэрээнд зааснаар 9 сарын 1-ний өдрөөс орон нутгийн иргэд, байгууллага аж ахуйн нэгжийн дотоодын нүүрсний хэрэгцээг нийлүүлэх ажил эхэлсэн.

Увс аймгийн Харганатын төмрийн хүдрийн ордоос хүдэр тээвэрлэж буй “ALGT” ХХК нь хүдрийн тээвэрлэлтээ манай аймгийн нутаг дэвсгэр дэх улсын болон олон улсын чанартай авто замаар тээвэрлэж байгаа бөгөөд аймгийн удирдлага, мэргэжлийн байгууллагуудын хяналт дор даацын хязгаарлалтыг баримталж, камаз маркийн тээврийн хэрэгслээр тээвэр гүйцэтгэж байна.

Зургаа: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар:

Аймгийн Засаг даргаар батлуусан удирдамжийн дагуу сумдын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга нараар ахлуулсан ажлын хэсэг Буянт, Мянгад, Дөргөн, Чандмань, Дарви, Зэрэг, Манхан сумдад ажиллаж, сумдын Засаг даргын Тамгын газар болон төсөвт байгууллагуудын үндсэн чиг үүрэг, стратегийн зорилт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, төрийн албаны стандарт хангалт болон цаг үеийн ажил, өвөлжилтийн бэлтгэл хангасан байдалтай газар дээр нь үзэж танилцан, үүрэг чиглэл, заавар зөвлөгөө өгч ажиллав.

Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн 2017 оны эхний хагас жилийн биелэлт ирүүлээгүй Буянт, Зэрэг, Үенч, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн биелэлт ирүүлээгүй Алтай, Булган, Буянт, Дуут, Манхан, Мөнххайрхан, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн биелэлт ирүүлсэн боловч шаардлага хангахгүй чанаргүй тайлан ирүүлсэн Дөргөн, Цэцэг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт сахилгын шийтгэл ногдуулж, хариу ирүүлэх талаар хугацаатай албан бичиг, зөвлөмж хүргүүлээд байна.

09 дүгээр сарын байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 3, Засгийн газрын 33 тогтоол, 11 хуралдааны тэмдэглэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3, Тэргүүлэгчдийн 80 тогтоол хүлээн авч аймгийн удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Долоо: Сумдын мэдээлэл:

Жаргалант сум: Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр:

Мал сүргийг гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 31000 толгой төл малд бруцеллезын вакциныг хийж гүйцэтгэв.

Сумын хэмжээнд 9 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар төмс 322 тн, хүнсний ногоо 785,6 тн, тэжээлийн ургамал 10 тн, үр тариа 12 тн-ийг хураан авч, малчид болон мал бүхий иргэд 720 тн байгалийн хадлан, гар тэжээл 150 тн, хужир шүү 300 тн-ийг бэлтгээд байна.

Газар зохион байгуулалт дэд бүтцийн чиглэлээр: сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн 09 дүгээр сарын 14-ний өдрийн 168 дугаар тогтоолоор айл өрхөөс авах хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоов.

Хот тохижуулах газарт үүрэг өгч Хотын хэмжээнд ажиллахгүй байгаа 466 гэрэлтүүлэг байснаас 216 гэрэлтүүлгийг засварлан ажилд оруулсан.

Нохой устгахад шаардагдах зардлын тооцоог хийж, сумын төсвөөс 7,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн 2 иргэнтэй гэрээ байгуулан ажилласны дүнд 231 нохойг буудаж, 65 нохойг тогонд цохиулах замаар нийт 296 нохойг устгууллаа.

Газрын даамлуудтай хамтран Улаан богочийн хороололд ажиллан нийт 274 хашаанаас 67 хашаа нурсан, 48 хашааны банзыг буулгаж авсан байгааг тогтоолоо.

Байгаль орчны чиглэлээр: “Цэвэрч Ховдчууд” аяны хүрээнд нийтдээ 3 удаа бүх нийтийн цэвэрлэгээний ажил зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 95 байгууллагын 2086 албан хаагч, оюутан залуус 12 багийн 1250 гаруй иргэн оролцож 226м³ буюу 81 машин хог хаягдлыг цэвэрлэн ачиж зайлууллаа.

Алтай сум:

Ахмадын Цагаан уул амралтанд 9 өндөр настныг амрууллаа.

Дарви сумаас 2 багийн дарга 5 малчныхаа хамт ирж удирдлагуудтай уулзаж цаг хүндэрсэн үед Барлаг, Алтангадас багийн нутагт ирж өвөлжих саналыг тавьж, Хөх булаг, Шар дав чиглэлд нутаг эргээд буцлаа.

Тахилт багийн ИНХ 09 дүгээр сарын 07-ны өдөр хуралдаж БЗД-ын эхний хагас жилд хийсэн ажлын тайлан, ОНХС-аар хийгдэх ажлын санал авах, Малжуулах төсөлд хамрагдах малчид сонгох зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Малжуулах төсөлд Б.Алтангэрэл, Б.Болдсайхан, З.Дэлгэрбат нарын 3 хүнийг сонгон хамруулахаар борлов.

Сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Хөндлөнгийн Тамтад 5 га газрын нөхөн сэргээх талаар тендерийн хурал хуралдаж, “Ногоон ирээдүй” төрийн бус байгууллага сонгон шалгаруултаас үйл ажиллагаа явуулах эрх авч, “Нутгийн хишиг” нөхөрлөл болон бусад нөхөрлөлтэй хамтран орон нутгаас 21 иргэн ажлын байраар хангадан ажиллуулах гэрээ байгуулахаар шийдвэрлэв.

ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 09 дүгээр сарын 20-ны өдөр хуралдаж, сумын Хүүхэд хамгаалалын хамтарсан багийн ажлын хэсгийг өөрчлөх тухай, Хүүхдэд ээлтэй дотуур байрны төслийн ажлын хэсгийг шинэчлэх тухай, 10 дугаар сарын 01-ний өдөр болох Барлаг багийн Иргэдийн хурлын төлөөлөгч сонгох нөхөн сонгуулийг хойшлуулах зэрэг асуудлуудыг хэлэлцсэн.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Залуучуудын зөвлөлийн дарга н.Гантогоо тэргүүлэгчдийн хамт ажиллаж, залуучуудын зөвлөлийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар нь Алтангадас багийн Засаг дарга Т.Азжаргал сонгогдсон.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас бичил уурхай эрхлэгчдийг өөр үйлчилгээ эрхлүүлэх чиглэлээр буцалтгүй 1.0 сая төгрөгийн төслийн уралдаан зарлаж, сумын амьжиргаа дэмжих зөвлөл, ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар ирсэн 4 төслийг оруулж Бодонч багийн иргэн Т.Ганцэцэгийн “Уран оёдол” төсөл шалгарсан.

Эрүүл мэндийн төвийн үйлчилгээний талаар: 9 дүгээр сард амбулаторийн үзлэгт 385 хүн/давхардсан тоогоор/ хамрагдсаны 20 өвчтөнг хэвтүүлэн эмчилсэн ба үүнээс дотор 16, хүүхэд 4 эмчлэгдэн гарсан байна. Аймгийн Амаржих газарт 13 эхийг шилжүүлснээр эсэн мэнд амаржиж, суманд төрсөн эх байхгүй. 9 сарын 15-ны өдөр “Болор” сангаас “Итгэл- хавдаргүй монгол” уриатай Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс эмч нар ирж 165 гаруй хүнд эмэгтэйчүүдийн үзлэг, оношилгоо хийж, зөвлөмж өгөв. 3 жирэмсэн эхийг эхний 3 сартай хяналтанд авч, 5 эхэд төмрийн бэлдмэл уулгаж, төрсний дараах 42 хоногтой эх, нярайн эргэлтийг 4 эхэд хийж, зөвлөгөө өгөв. Хөх, умайн хүзүүний хавдрын шинжилгээг 14 эмэгтэйгээс авсан. Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдвал зохих 30 хүүхдээс 28 хүүхдийг хамруулж, 94 хувьтай. Цусны ерөнхий шинжилгээ 18, шээсний шинжилгээ 29, төстийн оношлуураар ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээ 9, ВС вирусн маркерийн шинжилгээнд 11 онд хийснээс 1 хүнээс В вирус илрэв. Нян судлал 23, хеликобактер1, АСЛО-1, сахар1, цагаан хорхойн шинжилгээ 24 хүүхдээс авснаас 2 хүүхдэд илэрсэн.

Булган сум:

“Залуучууд ба сумын хөгжил” сэдэвт уулзалт, өдөрлөг зохион байгуулагдлаа. Өдөрлөгт 60 гаруй залуу хамрагдаж, сумын ИТХ-ын дэргэдэх Залуучуудын зөвлөлийг 17 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

09 сарын 15-18-ны өдрүүдэд сумын Нэгдсэн эмнэлгийн 80 жил, “Торгон нутаг” клубын 10 жилийн ой, Бүрэнхайрхан уулын тахилга наадам амжилттай зохион байгуулагдав. 1 дүгээр 12 жилийн сургууль дээр “Цахим номын сан” нээлтээ хийв.

Булган сумын иргэн Б.Мөнхтөр нь “Минжит Булган” цогцолбор сургуулийн нэг ангийг 20 сая төгрөгөөр бүрэн тохижуулан хүлээлгэн өглөө.

Сумын төвийн бүх нийтийн хогны цэвэрлэгээ зохион байгуулж, сумын төвийн орчмын хог хаягдлыг бүрэн цэвэрлэлээ. Хог цэвэрлэхэд 4 машин хогийг хогийн цэгт хүргэж ажилласан.

Буянт сум:

Иргэний бүртгэл, өргөдөл гомдол: Тайлант сард иргэдээс бичгээр 6 өргөдөл хүлээн авч 6 өргөдөл шийдвэрлэсэн байна. Иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээг нийт 352 иргэнд үзүүллээ. Үүнд: Шинээр төрсөн хүүхэд 56, гэрлэлт бүртгэл 23, нас баралт 18, иргэний шинэчилсэн бүртгэл 95, анх удаа иргэний үнэмлэх авч байгаа 16 настай – 43, 25 насны сунгалт – 27, 45 насны сунгалт – 25, эцэг тогтоолтын бүртгэл 10, эд хөрөнгийн анхны бүртгэл 55 хүлээн авч тус тус үйлчиллээ.

Эдийн засаг, төсөв, шилэн дансны үйлчилгээний чиглэлээр: Орон нутгийн төсвийн орлого 36,7 сая төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэл нь 28,0 сая төгрөг 76,2 хувийн гүйцэтгэлтэй байна. 09 дүгээр сарын байдлаар улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 160122,8 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагууд төлөвлөгөөний дагуу өөрийн байгууллагын 775054,5 мянган төгрөгийн санхүүжилтийг 100% авсан байна. Тайлант хугацаанд сум хөгжүүлэх сангийн дансанд үндсэн зээл, хүүгийн төлбөрт 30,5 сая төгрөг төвлөрүүлээ.

Спорт, соёл, урлагийн чиглэлээр: Соёлын төв 200.0 мянган төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэйгээс 185 мянган төгрөгийн орлого төвлөрүүлээ. Сумын Соёлын төвийн номын сангаас 6 төрлийн номоор 27 иргэнд хүрч үйлчиллээ. сумын “Ургацын баяр”-ыг зохион байгуулав.

Эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр: Эрүүл мэндийн төвд нийт үзлэг 167, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 68, өвчний учир амбулаториор 95, гэрийн идэвхитэй эргэлт 4 удаа явж үйлчиллээ.

Нийт 25 өвчтөн хэвтэж эмчлэгдсэн. Алсын дуудлагад 16 удаа явж цаг алдалгүй түргэн шуурхай үйлчилж байна. Жирэмсний хяналтанд шинээр 2 эх хяналтанд авсан, эхний 3 сартай 100% хяналтанд авч, зохих шинжилгээнд хамруулж хянаж ажиллаж байна. Товлолын дагуу нийт 34 хүүхдэд хөдөө багуудаар явж дархлаажуулалт хийснээр 99% хамрагдлаа.

9,7 сая төгрөгийн төслөөр Эрүүл мэндийн төвийн зуухыг шинэчилж бүрэн угсарч ажиллагаанд оруулсан

Боловсролын чиглэлээр: 2017-2018 оны хичээлийн жил эхэлж хамран сургах тойргийн цэцэрлэгийн насны 411 хүүхэд бүртгэлтэйгээс 140 хүүхдийн бүртгэлтэйгээр сургалтынхаа үйл ажиллагааг эхлүүллээ. Үүнээс бага бүлэг 2 настан – 26 , дунд бүлэг 3 настан 29 , ахлах бүлэг 4 настан – 40 , бэлтгэл бүлэг 5 настан – 45 хүүхдийн бүртгэлтэй байна.

СӨБ-ын цөм хөтөлбөрийн багшийг чадавхижуулах сургалтанд 3 багш хамрагдсан.

Хөдөө аж ахуйн салбарт: “Намрын ургацын баяр”-ыг 09 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулав. Халдварт болон празит өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга, тарилга туулгалт бруцлэзийн вакциныг 5 багт “Буянт Оргих Шим” МЭҮН тугал 110, хурга 3200, ишиг 5600 бүгд 8910 төлд, “Элсэн мандал” МЭҮН нь тугал 600, хурга 1930, ишиг 2000 нийт 3990, “Гурвалжин тан” МЭҮН нь тугал 1500, хурга 7200, ишиг 10000 бүгд 18700 төл малд бруцлэз өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтыг хийж байна.

Сумын хэмжээнд одоогийн байдлаар төмс 312 тонн, хүнсний ногоо 1235 тонн, тарвас 55 тонн, амтат гуа 6,0 тонн хурааж авлаа. Урьдчилсан байдлаар сумын аюулгүйн нөөцөд 50 тонн өвс, сумын хэмжээнд өвс 6400 тонн, гар тэжээл 105 тонн, давс, хужир шүү 250 тонныг бэлтгээд байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Сумын хэмжээнд 12 иргэнд холбогдох хуулийн дагуу хууль зүйн зөвлөгөө өглөө. “Монгол улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлт” сэдэвт бүсийн сургалт, хэлэлцүүлэгт оролцож, сумандаа тус хэлэлцүүлгийг зохион байгуулж нийт 473 хүн сургалт, хэлэлцүүлэгт хамрагдав. Хэсгийн төлөөлөгч болон цагдаа нар хэв журам сахиулахаар өдөр болон шөнийн эргүүлийг 19 удаа 143 цаг гарч, ахуйн дуудлагад 5 удаа явж ажиллав.

Дарви сум:

Соёлын төвтэй хамтран Мөнгөн аяга багт ургийн бичиг хөтлөлтийн сургалт, номын үзэсгэлэн, караоке дууны тэмцээн зохион байгуулж, 400 гаруй иргэдэд соёл мэдээллийн явуулын үйлчилгээ үзүүлсэн. “Номын баяр-2017” хөтөлбөр боловсруулан соёл, мэдээллийн цуврал арга хэмжээг зохион байгуулж байна.

Номын сан 70 уншигчдэд 145 номоор үйлчилж, номын фондоо уншигчийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан 1 сая төгрөгийн номоор баяжуулав.

Өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор халаалтын системийн бүрэн шинэчлэл хийх хүсэлтийг бүх байгууллагуудад уламжлан, мод, нүүрсний татан авалт 80 хувьтай, дотоод цэвэрлэгээ, дулаалга хийж байна

Сургуулийн дотуур байранд их засварт хийж, боловсон 00 суурилуулан сурагчдын амьдрах орчин, нөхцөлийг сайжруулав.

Хүүхдийн цэцэрлэгийн дээврийн засвар хийлгэж, 10 хаалга шинэчлэв. БСШУЯ-наас иж бүрэн гэр цэцэрлэг олгов.

Дөргөн сум:

Хөдөө аж ахуйн чиглэлээр : Өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангаж Агваш баг 350 тн хадлан, 50 тн гар тэжээл, 80 тн хужир шүү, Аргалант баг 330 тн хадлан, 50 тн гар тэжээл, 90 тн хужир шүү, Сээр баг 340 тн хадлан 59 тн гар тэжээл, 100 тн хужир шүү, Өгөөмөр баг 182 тн хадлан, 61 тн гар тэжээл, 43 тн хужир шүү бэлтгэж сумын дүнгээр өвөлжилтийн бэлтгэл байдал 93 %-тай хангагдсан. Мөн энэ сард бог малын 6 шинэ хашаа барьсан. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хурга 9082, ишиг 33451, тугал 1041 төл малд вакцин хийсэн.

Нийгмийн даатгалын чиглэлээр: 09 сард 347 тэтгэвэр авагчдад 91800.0 мянган төгрөгийн санхүүжилтаар тэтгэвэр бүрэн тавьж олгосон байна. Үүнд : Өндөр насны тэтгэвэр авагч 246, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 33, Тахир дутуугийн тэтгэвэр авагч 68. Мөн шинээр энэ сард 4 иргэнд өндөр настны болон тахир дутуугийн, тэжээгчээ алдсан тэтгэвэр тогтоосон. Сайн дурын даатгалд нийтдээ 60 даатгуулагчийн 3518.0 төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн. Төсвийн байгууллага болон ААН-үүдээс нийтдээ 21106.0 төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн. Энэ сард 2 даатгуулагч шинээр сайн дурын даатгалын гэрээ байгуулсан. Эрүүл мэндийн даатгалд 20 хүний 941.0 төгрөгийн орлого оруулсан.

Тэтгэмжийн даатгалын сангаас 7 эхэд 7550.0 төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж, 2 өндөр насны тэтгэвэр авагчид 2000,0 төгрөгний оршуулгын тэтгэмж олгосон.

Төсөв санхүү статистик чиглэлээр :Сум хөгжүүлэх сангийн зээл олгох төсөл сонгон шалгаруулах зарыг ард иргэдэд нээлтэй зарлаж, 16 төсөл хүлээн авч, Төсөл сонгон шалгаруулах зөвлөл хуралдаж 13 төслийг дэмжиж, 3 төслийг буцаасан. Зээлийн нийт хэмжээ 50.0 сая төгрөг, Зээлийн жилийн хүү 3%, сарын хүү 0.025 % зээлийг 36, 24, 12 сарын хугацаагаар тус тус олгосон.

Газар зохион байгуулалтын чиглэлээр: Газрын кадастрын мэдээллийн сангийн хяналт шалгалт “Лэнд менежер” программ хангамжын давтан сургалт 9 дугаар 10-16-ны хооронд болж, газрын даамал Б.Ганцэцэг хамрагдав.

Улсын бүртгэлийн чиглэлээр: 8 төрлийн бүртгэлээр: төрөлт-12, нас баралт -1, үрчлэлт -2, шилжиж ирсэн 6, шилжиж явсан -6 иргэний үнэмлэх шинээр захиалсан болон 25,45 насны сунгалт хийлгэсэн - 13, цахим үнэмлэх дахин захиалсан-4 иргэний бүртгэлийг тус тус хийж, 20 хүнд иргэний цахим үнэмлэх олгосон

Татварын чиглэлээр : 9 дүгээр сарын 10-ны дотор НӨАТ-ын тайланг 5 аж ахуйн нэгжээр бүрэн гаргуулж, тушаасан.

Автын татварын өртэй 12 татвар төлөгчийн өрийг барагдуулж, 1 татварын өртэй татвар төлөгчид мэдэгдэх хуудас хүргүүлсэн.

Байгаль хамгаалах чиглэлээр: Сумын төвийн эргэн тойронд их цэвэрлэгээ хийж, хогийг хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлж устгасан.

Аймгийн Хот тохижилтийн газартай хамтран Өгөөмөр багийн Засаг дарга, Байгаль хамгаалагч нар 60 нохойг устгаж, хогийн нэгтсэн цэгт төлөвлөрүүлсэн.

Эрүүл мэндийн төвийн ажлын талаар: Ерөнхий боловсролын сургуулийн 1-12-р ангийн хүүхдүүдэд үзлэг хийж, харааны сул болон харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн харааг тогтоож, нарийн мэргэжлийн эмчид үзүүлэхийг зөвлөж, нүдний шил хийлгүүлэхээр зөвлөмж өгсөн.

Сургуулийн ажлын талаар: 9-р сарын 1-ний хичээлийн шинэ жилийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, сурагчдын дунд спортын тэмцээнүүдийг зохион байгууллаа.

2017 оны хичээлийн жилд 5 орон тоо гарч, сонгон шалгаруулалт зарлаж, Бага ангийн багшийн түр орон тоон дээр 3 багш, газарзүйн багшийн бүр орон тоон

дээр 1 багш, нийгмийн ухааны багшийн түр орон тоон дээр 1 багшийг шалгаруулж авсан.

Сумын хэмжээн дэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг гаргаж, Ерөнхий боловсролын сургуульд 14, насан туршийн боловсролд 7, гэрээр 1 хүүхдийг хамруулан сургаж байна.

“Нэг сэтгэл – Нэг тус” аянд сургуулиараа нэгдэж цагдаагийн “Сүлд” чуулгын дуучин Ц.Бизъяад 52850 төгрөгийн тусламж үзүүлэв.

09 сарын 25-28-ны хооронд 1-5-р ангийн бүх сурагчдаас Математик, Монгол хэлний хөндлөнгийн шалгалт авч гарааг тогтоов.

Соёлын ажлын талаар : Өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор Мянгад сумын соёлын төв, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчидтай хамтран “Хонхон дуутай аялгуу” тоглолтыг хичээлийн шинэ жилийн нээлтийг тохиолдуулан зохион байгууллаа.

Албан байгууллагуудад Номын богц аялуулж ном хандивлах хөдөлгөөн өрнүүлж фондоо 20 гаруй номоор баяжууллаа.

Цэцэрлэгийн ажлын талаар : Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт нийцүүлэн сурах хүсэл тэмүүлэл төрүүлэх, цэцэрлэгтээ явахад дуртай сонрхолтой болгох зорилгоор сургуулийн гаднах талбайг дугуйгаар чимэглэж, тохижуулсан.

Дуут сум:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит хуралдааныг 1 удаа хийж 2 асуудал хэлэлцэн 1 тогтоол гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сумын ИТХ-д дээд газраас энэ сард хугацаатай бичиг 1 ирж хугацаанд нь хариуг нь явуулсан.

ЗДТГ-ын үйл ажиллагааны мэдээлэл: Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд төрийн албан хаагчид, иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 130 гаруй төрийн албан хаагч, иргэд оролцсон.

09 дүгээр сарын байдлаар татварын орлогын төлөвлөгөө 18,300,0 төгрөг төлөвлөгдсөнөөс 39,245,0 төгрөг орж 163 хувийн биелэлттэй байна.

Сумын иргэний бүртгэлийн мэдээллээр 9 дүгээр сард төрөлт-10, гэрлэлт-4, шилжин явсан-10, шилжин ирсэн-6, иргэний үнэмлэх захиалсан-15, иргэний үнэмлэх олгосон-13, хүүхэд үрчлэлт-1, нас баралт-1, эцэг тогтоолт-3 иргэн бүртгүүлсэн байна.

Сумын Засаг даргын Тамгын газарт 09 дүгээр сард нийт 27 бичиг ирснээс хугацаатай 6 бичиг байна. Үүнээс хугацаандаа явсан 4, хугацаа болоогүй 2 бичиг байна.

Арьс, шир, хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан 44 малчин, мал бүхий өрхийн ноосны материалыг бүрдүүлж аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Баруун 5 аймгийн Хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийн уулзалт, зөвлөгөөнд хамрагдаж, ЯМАХА маркийн мотоциклийг хүлээн авлаа.

2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, мэдээг хүснэгтээр гаргаж аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

“Хавх тавиагүй ууланд хамаг амьтан жаргалтай-3” аяны хүрээнд 3 өдөр ажиллаж 7 машин, 12 мотоцикльд үзлэг шалгалт хийж зөрчлийг арилгуулж, 2017 оны ангийн тооллогыг агнуурын мэргэжлийн байгууллагатай хамтран зохион явууллаа.

2017 онд суманд тусгай зөвшөөрлөөр 4 тэх агнах төлөвлөгөөний дагуу 2 компанитай гэрээ байгуулан 4 тэх агнаж дууссан. Тэх агнах үйл ажиллагаанд сумын

Засаг даргын Тамгын газраас хяналт тавьж 2 удаа очиж шалгасан.Тэх агнах үйл ажиллагаа хуулийн дагуу явагдлаа.

12 жилийн ахлах сургуулиас зохион байгуулсан ажил: Сумын ахлах сургуульд 2017-2018 оны хичээлийн жилд шинээр нэгдүгээр ангид 28 сурагч элсэн орсон.Нийтдээ сургуульд 214 сурагч суралцаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо-12, эмнэлэгт хэвтэж гарсан хүний тоо-12, Төрөлт суманд-0, аймагт-4, нас барсан хүн-1, гэрийн нас баралт-1, алсын дуудлага-14, эмчийн үзлэг- 0, АД, ЧШ-гийн үзлэг-0, жирэмсний хяналтанд хамрагдсан-1, эхний 3 сартай хяналтанд-0, 4-6 сартай хяналтанд-1, товлолын вакцинд 18 хүүхэд хамрагдсан.

Цэцэрлэгээс зохион байгуулсан ажил: Хичээлийн жилийн нээлтийг зохион байгуулав. Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах, хүүхдийн сурч, хөгжих таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд 3 бүлгийн 6 өрөөнд засвар хийж нийт 780,000 мянган төгрөг зарцуулсан.

Анги бүлгүүд хүүхэд бүрийн хөгжих таатай орчин бүрдүүлэхэд санал санаачлага гаргаж “Нэг хүүхэд-нэг тоглоом” аян зохион байгуулж, Бага бүлгийн эцэг эхчүүд 250 мянган төгрөгийн үнэтэй зурган халаалт хандивлав. Дунд, ахлах бүлгийн нийт 5 эцэг эхчүүд 5 төрлийн тоглоом бэлэглэсэн.

Одоогоор байгууллагад 10 тн нүүрс, 2 тн аргал байгаа болон түлшний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 4 тн аргал, 25 тн нүүрсийг 9 сарын 30 гэхэд авахаар санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдэж жолооч нартай тохиролцсон.

Халаалтын тогооны асуудлыг шийдвэрлүүлэхээр аймгийн БСУГ-т 2 удаа асуудлыг уламжилж мэргэжлийн байгууллагаар төсвийг хийлгэж хүргүүлсэн, одоо ашиглаж байгаа тогоог цаашид ашиглаж болохгүй гэсэн МХГ-ын дүгнэлт гарсан боловч хагарсан 2 тогоог засвар хийж халаалт эхлэхэд бэлэн болгосон.

Хамран сургах тойргийн нийт 197 хүүхдээс үндсэн бүлэгт -84, явуулын сургалтанд-53 бусад аймаг сумын цэцэрлэгүүдэд -26 хүүхэд хамрагдаж хамран сургалт 82,8%-тай байна.

Зэрэг сум:

Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Малчин, удирдах ажилтнуудын зөвлөгөөн”-д амжилттай оролцож, сумын өвөлжилт хүндэрч болзошгүй байдал, цаашид авах арга хэмжээний тухай тайланг хэлэлцүүлж холбогдох газарт хандан ажиллаж байна.

Монгол улсын Зэвсэгт хүчний жанжин штабаас хурандаа н.Чулуунзагдаар ахлуулсан ажлын хэсэг Локаторын цэргийн анги байгуулах асуудлаар харилцан ярилцаж, сум орны нөхцөл байдалтай танилцаж ажиллалаа.

Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн хэлэлцүүлэг сургалтыг Бургасан, Хөндлөн багуудад зохион байгуулж нийт 400 хүнийг хамруулан иргэдийн санал авах үйл ажиллагааг зохион байгуулж тайланг санлын хуудсын хамт аймгийн ЗДТГ-т хүргүүллээ.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах Засгийн газрын 186 тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 01 албан даалгавар, аймгийн Засаг даргын 05, 07 албан даалгаврын хүрээнд ажлын хэсэг байгуулж, 3 бүлэг 27 заалт бүхий ажлын төлөвлөгөө гаргаж ард иргэд, албан байгууллага, малчдад зөвлөгөө өгч шаардлага тавьж ажиллаж байна. Онцгой байдлын газартай хамтран Бургасан багийн нутаг дэвсгэр Цагаан арал гэдэг газар 2 удаа хүний буруутай үйл ажиллагаанаас гарсан 8 орчим га талбайг хамарсан ой хээрийн түймрийг ард иргэд, төрийн албан хаагчдын оролцоотой 9 сарын 12-27-ны хооронд давхардсан тоогоор 300 хүн ажиллаж 2.5 сая төгрөгийн зардал гаргаж ажиллалаа.

Манхан сум:

Засаг даргын тамгын газар: Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээллийг сумын хэмжээнд 3 багт бүсчлэн зохион байгуулж 450 саналын хуудас бөглүүлэн хууль зүйн хэлтэст хүргүүллээ.

“Хоггүй Ховд” аяны хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж 130 иргэн, 120 хүүхэд оролцож 5 машин хогийг бөөгнүүлж, зохих цэгт хүргүүлэн ажиллалаа.

Аварга малчдын санаачлагаар “Малчин” санг байгууллаа.

“Манханд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаа зохион байгууллаа.

Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хүрээнд: НББ-г бүрэн хөтөлж боловсруулан журнал хөтлөн шилэн дансны хөтлөлтийн хяналт хийв. Худалдан авах ажиллагааны хуулийн дагуу Ковш худалдан авав.

Хууль эрх зүйн бодлогын хүрээнд: Засаг даргын Тамгын газраас гарсан эрх зүйн акт, тушаал, Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлд хяналт тавих, зөвлөгөө өгөх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Төслөөр болон хувиараа газар торлосон иргэдийн газарт үзлэг хийж, сумын ИТХ-аас гарсан тогтоолын дагуу хаваржааны газарт тор татах хэмжээг 2 га гэж заасан ба ажлын хэсэг иргэдийн торыг хэмжиж хэмжээ хэтрүүлэн тор татсан иргэдэд шаардах хуудас бичиж өгсөн.

Бүрэн дунд сургууль: 2017-2018 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн баярыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулав.

Нэгдүгээр ангид элсэн орж буй сурагчдыг бүртгэн 3 бүлэгт хуваан хичээллүүлж байна.

Сургуулийн дотуур байранд 138 хүүхдийг хүлээн авч үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

1-12 дугаар ангийн сурагчдын хичээлдээ ашиглах шинээр хэвлэгдэн гарч буй номнуудаас тус сургуульд хуваарилагдсан номыг татан авч сурагчдад олгож байна.

1-5 жилдээ ажиллаж буй багш нарын дунд “Багшийн ёс зүйг эрхэмлэх нь” эссэ бичлэгийн уралдааныг зохион явуулж шалгарсан эссэг БСУГ-т хүргүүллээ.

Соёлын төв: 09 сарын 01-д хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаанд оролцож ахлах ангийн сурагчдын дунд бүжиг явуулав.

Хүүхдийн цэцэрлэг: Хичээлийн жилийн элсэлтийн бүртгэлийг 08 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд явуулж 130 хүүхдийг цэцэрлэгт элсүүлсэн ба хичээлийн шинэ жилийн нээлтийг зохион байгууллаа.

Багш нар элсэлтэнд бүртгэгдсэн 130 хүүхдээс хичээл, ариун цэврийн хэрэглэгдэхүүнийг жагсаалтын дагуу 126 хүүхдээс авч сургалтын үйл ажиллагааг эхлүүлсэн байна.

Багш нарын 3 дугаар улирлын ажлыг дүгнэж улирлын мөнгөн урамшууллыг тооцож олголоо.

Эрүүл мэндийн төв: Эрүүл мэндийн төв нь 4 их эмч, 22 ажилтан, нийт 26 орон тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. 09 дүгээр сарын 26-ны байдлаар 315 хүнд үзлэг шинжилгээ хийсэн.

Урьдчилан сэргийлэх үзлэгт 112 хүн хамруулсан ба эмнэлэгт 30 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна.

Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 12 хүүхэд хамруулсан. 1 эх эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 13 дуудлаганд үйлчилсэн байна.

Байгаль орчин: Усны тооллого явуулж дүн мэдээг усны сав газарт хүргүүлэв.

Шатахуун түгээх станцын болон Гурван замын дагуу байрлалтай цайны газруудын үйл ажиллагаанд хяналт хийж ус ашиглах дүгнэлт гаргуулах мэдэгдэх хуудас өгсөн.

Хоггүй Ховд сарын аяны хүрээнд сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан хог хаягдлын цэвэрлэгээг 7 хоног бүрийн 4 дэх өдөр бүх нийтийн цэвэрлэгээг хийж 5 машин хог хаягдлыг зохих цэгт хүргүүлэв. Үүнд 220 сурагч, 130 гаруй иргэн оролцлоо.

Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд: Сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажил 90 хувьтай хангагдсан.

Сум хөгжүүлэх сангийн зээлд 4 иргэний төслийг хэлэлцүүлж зохих санхүүжилтийг олгосон.

Баянгол багийн мал угааллагын ванныг сумын орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг хүлээж авлаа.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мал сүргийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор МЭҮН-үүдтэй хамтран Бруцеллэз өвчний вакцинийг заавар журмын дагуу татан авч вакцинжуулалтыг 08 сарын 28-наас 9 дүгээр сарын 10-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Мөнххайрхан сум:

Олон нийтийг хамарсан ажил: “Эмийн зохистой хэрэглээ” сэдэвт сургалт, сурталчилгааг зохион байгуулж, 46 хүн хамрагдсан.

Эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмч нарын үнэ төлбөргүй үзлэг, оношлогоог Улаабаатар хотын эмч нартай хамтран 09 сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 104 эмэгтэй хамрагдсан.

12 жилийн сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж 3-5 насны нийт 65 хүүхэд үзлэгт хамрагдсан. 6-18-насны нийт 452 хүүхэд үзлэгт хамрагдсан. Үзлэгээр амны хөндий, нүд, чих хамар, хоолой, бие бялдарын өсөлт, хөгжлийг тодорхойлсон.

Нийт дуудлага-10 үүнээс том хүний-7, хүүхдийн дуудлага-3 байсан. Дуудлаганд цаг алдалгүй үйлчилсэн. Эмийн бус эмчилгээгээр нийт-27 хүн хамрагдсан. Дархлаажуулалтанд-20 хүүхэд хамрагдсан.

Мөст сум:

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн ээлжит хурлыг хийж сумын ИТХ-ын төлөөлөгчдийн өдрийг тэмдэглэх тов гаргаж, удирдамж батлах, төрийн дээд шагналд зарим хүмүүсийг тодорхойлох тухай, “Хужирт” нөхөрлөлд ангийн бүс нутгийг тогтоох тухай, Амьжиргаа дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөн шинэчлэх зэрэг асуудлыг хэлэлцэж 3 тогтоол гаргасан.

Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл: Сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх аж ахуй нэгжийг шалгаруулах тендэрийг зохион байгуулж, шалгарсан аж ахуй нэгжүүдтэй улирлаар гэрээ хийж ажиллахаар болов.

Баянхайрхан багийн нутаг Бамбагарын оройд Жи-Мобайлын антен байрлуулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

Нийгмийн даатгал: 09-р сарын 27-ны байдлаар нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр 2 даатгуулагч хамрагдсан ба нийт 39 даатгуулагчийн 1474.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 15 даатгуулагчийн 624.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлээр 3 байгууллагын 7978.9 мянган төгрөг, нийт 8747.6 мянган төгрөгийн орлого орж нийт орлогын төлөвлөгөө 89 хувьтай байна.

Сангаас 3 төрлийн тэтгэвэрт 2 арилжааны банкаар 101748.5 мянган төгрөг, 3 төрлийн тэтгэмжинд 3090.6 мянган төгрөг, нийт 104839.1 мянган төгрөг тавьж

олгосон ба энэ сард тэтгэврийн сунгалт хөдөлгөөнийг 7 тэтгэвэр авагч хийлгэсэн ба шинээр 2 даатгуулагч тэтгэвэрээ тогтоолгосон байна.

Аймгийн ЭМНД-ын хэлтсийн ажлын хэсэгтэй хамтран Нийгмийн даатгалын Нээлттэй хаалганы өдөрлөгийг 09 сарын 16-ны өдөр зохион байгуулан ажиллалаа.

Нийгмийн халамжийн чиглэлээр: 9-р сарын 1-нээс эхлэн Нийгмийн Халамжийн сангаас 4 ХБИргэн сар бүр 140000 төгрөг, Тэжээгчээ алдсны тэтгэмжид 12 хүүхэд, ахмад настны асаргаанд 57 хүн, ХБИргэний асаргаанд 18 хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаанд 11 хүүхэд, Бүтэн өнчин буюу асрамжинд байгаа 3 хүүхэд, 16 дээш насны эм тарианы үнэ ХБИргэн 10 хүн, ахмад настан 18 хүн, 16-аас доош насны эм тарианы үнэ 11 хүүхэд сар бүр 140000 мянган төгрөг тус тус авч байна.

Ахмад настанд унааны нэг талын зардалд 2 хүн нийтдээ 130000 төгрөгний хөнгөлөлтийг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.

Сумын хэмжээнд 18 өрхийн 50 том хүн, 54 хүүхэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр: шинээр төрсөн 5, шинээр гэр бүл болсон 5, овог нэрээ сольсон 2, нас барсан 2, шилжиж ирсэн өрх 1, иргэн 9, шилжиж явсан өрх 2, иргэн 12, иргэний үнэмлэх шинээр 2, сунгалт 5, дахин шинээр авсан 5 иргэн байна.

Мал аж ахуй, үйлдвэр үйлчилгээний чиглэлээр: Бруцлэзын 19 вакциныг МЭҮН-д хувиарлан өгч гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан. Тарилгын акт хүлээн эвч ХХАА газарт хүргүүлж ажилласан.

2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын тайланг ХХАА-н газарт хүргүүлж мөн аймгийн комисст хүлээлгэн өгсөн. МЭҮН-ийг мал угаалагын ажил зохион байгуулж ажиллаж байна.

Газар зохион байгуулалт: Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд орсон газруудын зураг хийж газар олгож эхэлсэн. Гэр бүлийн хэрэгцээнд 5 иргэнд өмчлөл. Өвөлжөө, хаваржааны зориулалтаар 10 иргэнд газар эзэмшүүлж ЛМ праграмм оруулж шийдвэрлэсэн.

Байгаль орчны чиглэлээр: Сумын хэмжээний ерөнхий агнуур зохион байгуулалтын тооллогыг “Уламжлалт ав компани” биологич нартай хамтран сумын хэмжээний агнуурын бүс нутагт тооллого зохион байгууллаа.

Сургууль, цэцэрлэг, соёлын төвөөс зохион байгуулсан ажил: Сургууль энэ хичээлийн жилд 596 сурагч 41 багш, 30 ажилчидтай сургалт хүмүүжлийн ажлаа явуулж эхлээд байна. Дотуур байранд суух сурагчдыг бүртгэж одоо 70 гаруй сурагч сууж байна. Шинээр 1-р ангид нийт 49 сурагч элсэн суралцаж байна.

Сурагчдын зуны даалгавраар 2-дээш ангийн сурагчдаас 1 уут аргал 10 ш сонгино хураан авч нийт 410 гаруй уут аргал, 30 кг сонгиныг дотуур байрны түлш, хүнсэнд нөөцөллөө.

Цэцэрлэг: 9 сарын 1-нд хичээлийн жилийн нээлтээ хийж, бүлгийн хүүхдүүдийн дэлгэрэнгүй судалгаа болон статистик мэдээ тайланг гарган сургалтын үйл ажиллагааг хэвийг явуулж байна.

Эмнэлэг, эрүүл мэндийн чиглэлээр: Нийт үзлэг 585 үүнээс : Урьдчилан сэргийлэх үзлэг -280, гэрийн идэвхтэй хяналт- 100, дуудлагаар -55, жирэмсний хяналт шинээр 6 тус тус иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэж ажилласан байна.

Мянгад сум:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааныг 1

удаа зохион байгуулж, сумын Засаг даргаас өргөн мэдүүлсэн асуудлын дагуу Мянгад Шим-Ус ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнийг томилох, Улиастайн эхний рашааны ашиглалт, хамгаалалтыг сайжруулах журам батлах, Хөрөнгө худалдан авах зэрэг асуудлуудыг хэлэлцүүлэн амжилттай шийдвэрлэж 4 тогтоол гарган хэрэгжүүлээ.

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Засаг даргын Тамгын газар нь энэ сард дээд байгууллагуудаас нийт 8 албан бичиг хүлээн авсанаас хугацаатай 4 бичиг байсныг хугацаанд хүргүүлж, нийт 12 албан бичгийг холбогдох байгууллагуудад явуулсан байна.

Иргэдээс ирүүлсэн ажилд орохыг хүссэн 2, улсын бүртгэлийн чиглэлээр 39, Нийгмийн даатгалын чиглэлээр 8 нийт 50 өргөдөл хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд бүрэн шийдвэрлэлээ.

Шинээр төрсөн хүүхэд 4, гэрлэлт 4, нас баралт 1, эцэг тогтоолт 3, шилжин явсан 4, шилжин ирсэн 1, иргэний цахим үнэмлэх 13, өргөдөл байгаа ба хуулийн хүрээнд бүртгэл, мэдээллийн үйлчилгээг бүрэн хүргэлээ.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын үйл ажиллагааны мэдээлэл: Нийгмийн халамжийн тэтгэвэрт 85 иргэнд 1190,0, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмж 46 иргэнд 1840,0 хөгжлийн бэрхшээлтэй иргэн асарч буй 54 иргэнд 6486,0 мянган төгрөг олголоо.

Нийгмийн даатгалын ажлын хүрээнд сайн дурын даатгалд 35 иргэнээс 1750,8 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 32 иргэнээс 1350,0 мянган төгрөгийн орлого орууллаа. Тэтгэврийн даатгалын санд 105125,0 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр настны тэтгэврийг 363 хүнд 80963,0, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 32 хүнд 7996,0, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 75 иргэнд 19925,0, ҮОМШӨ-ний сангаас 1 иргэнд 305,3 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 8 иргэний хүсэлтийг хүлээн авч шинээр тэтгэвэр тогтоосон байна. Хүүхдийн цэцэрлэг 2017-2018 оны хичээлийн шинэ жилийн нээлтийг 4 бүлэгт 112 хүүхэд хүлээн авч сургалт хүмүүжлийн ажлаа эхлүүлээд байна.

Дүйцсэн хөтөлбөрөөр сурч байгаа сурагчдын хамт 483 хүүхэдтэйгээр сургалт хүмүүжлийн ажлаа хэвийн явуулж байна. Дотуур байранд нийт 103 хүүхэд хүлээн авч, сурагчдын хүнсний хэрэгцээнд шаардагдах төмс, хүнсний ногоо, жимсний нөөцийг бүрэн бүрдүүлсэн байна.

Эдийн засаг, төсөв, санхүүгийн салбарын үйл ажиллагааны мэдээлэл:

Орон нутгийн төсвийн орлогод 9 дүгээр сард 3360,0 мянган төгрөг оруулахаас аймгийн төсөвт 6600,0, төвлөрсөн төсөвт 205,0 мянган төгрөг оруулж орлогын төлөвлөгөөг 84.3 хувиар биелүүлсэн байна.

Үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчин, газар зохион байгуулалт, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааны мэдээлэл: “Түм дэлгэрэх” ХХК-тай карьер ашиглах гэрээ байгуулан 3000 м3 хайргыг 4000 төгрөгөөр үнэлэн 50 хувийн төлбөр болох 2,0 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээд байна.

Суманд Дэлхийн банкны санхүүжилтээр баригдах 10 мВт-ын Нарны сэргээгдэх эрчим хүчний үйлдвэр барих зориулалтаар 20 га газрыг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-д эзэмшүүлэхээр гэрээ байгуулж, гэрчилгээ олголоо. Мөн 2017 онд газрын төлбөрт 3560,0 мянган төгрөг оруулахаас 9 дүгээр сарын байдлаар 2515,2 мянган төгрөгийг аймгийн Төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлээд байна.

“Шилмэл болон шилдэг” сортын төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний, “Шилмэл мал”-ын үзэсгэлэн худалдааг 9 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулав.

2017-2018 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, сумын аюулгүйн нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд 4500 тонн хадлан, 250 тонн гар тэжээл

бэлтгэж, сумын төвийн албан байгууллагууд урсгал засварын ажлыг бүрэн хийж, шаардлагатай нүүрснийхээ 30 хүртэлх хувийг татан аваад байна.

Эрүүл мэндийн салбарын ажлын талаарх мэдээлэл: 09 дүгээр сард нийт 244 амбулаторийн үзлэг хийж 15 иргэнийг хэвтүүлэн эмчилж 18 алсын дуудлагаар үйлчилж, 0-3 сартай 11 жирэмсэн эхийг эрт хяналтанд авч, энэ сард хөх умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих нийт 9 эмэгтэйчүүдийг 100 хувь шинжилгээнд хамруулж ажиллалаа.

“Хүүхдийн хараа хамгаалах өдөр”-ийг үндэсний хэмжээнд зохион байгуулж, 254 сурагчдын харааг шалгаж, үүнээс 9 сурагч сул хараатай илэрч, цаашид мэргэжлийн эмчид хандахыг зөвлөн ажиллалаа.

Тариаланчдын эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх үзлэгийг нийт 26 иргэдэд хийж үүнээс элэгний В,С вирусн шинжилгээнд хамрагдаагүй байсан 13 иргэдээс илрүүлэг шинжилгээ авч ажиллалаа.

Соёлын ажлын талаар: 09 дүгээр сарын 04-05-ны өдрүүдэд зэргэлдээх сум болох Дөргөн сумын Соёлын төвтэй хамтран “Намар цагийн дуулал” тоглолтыг хийж 2 сумын иргэдэд үйлчиллээ.

Мөн ЭМТ-тэй хамтран тус сумын Гахайт багийн иргэдэд “Хэн сайн дуулах” вэ дуун цэнгүүнийг зохион байгуулан ажиллалаа.

Үенч сум:

Засаг даргын 2017 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2017 оны А/74 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд сумын бэлтгэсэн байгалийн хадлан 5437 тн, сумын аюулгүй нөөцөд 40 тн өвс бэлтгэж үр тариа 85тн, төмс 27,1тн, байцаа 6,9 тн, лууван 3,6 тн, шар манжин 4,9тн, улаан манжин 0,5тн, сонгино 1,6тн, өргөст хэмх 0,3 тн ургацыг хурааж авсан. Засаг даргын Тамгын газрын туслах аж ахуй болох чацарганы ургацаа хурааж 1,4 тн байгалийн цэвэр өтгөрүүлсэн шүүс бэлтгэж хадгалсан.

Сумын Засаг даргын 2017 оны А/86 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан тугал 1911, хурга 12722, ишиг 23320 нийт 37953 толгой төл малд бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийж, ариутгал халдваргүйжүүлэлтэнд малын хашаа 15, малын тоног хэрэгсэл 2, уст цэг 2, зоорь агуулах 5 үзлэг шалгалтанд хамрагдсан. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилтын хүрээнд МоЭнКо ХХК-тай 1500 тн нүүрсний гэрээ байгуулан 09 дүгээр сарын 25-наас албан байгууллагууд татан авалт хийж, 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн айл өрхүүд, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлэхээр тээвэрлэлт хийгдэж байна. Суманд 134458 толгой мал, хилийн зурвас бүс нутагт 27533 толгой мал өвөлжих урьдчилсан тооцоо гарсан. Байгаль хамгаалагч нар 8 болон 9 дүгээр саруудад хяналт шалгалт хийж тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх эргүүл хийж ан амьтанд биотехникийн аргаар Хар чулуутын нуруунд 1 тн давс, хужир тавьсан.

6 настай сургуульд хамрагдаж чадаагүй 4 багийн нийт 23 хүүхдийн эцэг эхтэй биечлэн уулзаж, урилга өгөв. Хүүхдийн цэцэрлэгийн бэлтгэл бүлэгт 52 хүүхэд, ахлах бүлэгт 70 хүүхэд, дунд бүлэгт 65 хүүхэд бага бүлэгт 60 хүүхэд нийт цэцэрлэгт 250 гаруй хүүхэд бүртгэгдэн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Мөн Жаргалан болон Цагаан түнгэ багуудын 55 хүүхдийг гэр цэцэрлэгт хамруулан сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулж байна.

Ховд сум:

Сумын ИТХ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Сумын ИТХ-ын тэргүүлэгчид 1 удаа хуралдаж, зарим иргэдийг төрийн одон медальд тодорхойлох, Хөх сэрхийн тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн зөвлөл байгуулах,

ЗДТГазарт зарим хөрөнгө авах зөвшөөрөл олгох зэрэг асуудал хэлэлцэж тогтоол, шийдвэрүүдийг гаргав.

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Өвөлжилтийн бэлтгэл хангах сумын Засаг даргын А/113 дугаар захирамж гарган ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Сумын 5 багт мал өвөлжүүлэх нийт 665 өрхийн 201849 толгой мал ба хонин толгойд шилжүүлэхэд 277836 өвөлжих төлөвтэй байна. Малын төрлөөр үзэхэд тэмээ 634, адуу 5880, үхэр 6968, хонь 69490, ямаа 135787 өвөлжихөөр байна. Сумын аюулгүйн нөөцөнд нийт 36.8 тн өвс бэлтгээд байна.

Сумын ЗДТГазарт хугацаат 4 албан бичиг ирж, 2 албан бичгийн хариуг хугацаанд хүргүүлж, 2 албан бичиг хугацаа болоогүй болно.

Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого, газрын харилцааны хүрээнд: Сумын Засаг даргын А/39 дүгээр захирамж гарган малын шилжилт хөдөлгөөн, урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, угаалга, туулгалт боловсруулалтын байдалд МЭҮТасаг тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа.

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: Сумын Эрүүл мэндийн төвд тухайн сард 9 өвчтөн хэвтэж эмчилгээ хийлгэсэн. Үүнд Дотрын тасагт –9 хүн, Эрүүл мэндийн төвд тухайн сард алсын болон ойрын дуудлага 49 бүртгэгдсэн байна. Үүнээс ойрын дуудлага -32, алсын дуудлага-17 байна.

Мөн товлолын вакцинжуулалтанд 53 хүүхдүүдийг хамруулсан. "Элэг бүтэн монгол үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд 36 хүн шинжилгээнд хамрагдсан.

ЕБСургууль, цэцэрлэгийн хийсэн ажлын чиглэлээр: Сургуулийн багш нарын зөвлөлийн анхдугаар хуралдааныг зохион байгуулж, 2017-2018 оны хичээлийн жилийн зорилго, зорилт, сургуулийн дүрэм, дотоод журам, бүтэц орон тоо, багш ажилчдад нэмэгдэл олгох журмуудыг тус тус баталж мөрдөн ажиллаж байна.

Өргөдөл гомдлын талаар: Сумын Засаг даргын Тамгын газарт 5 иргэн өргөдөл ирүүлж, 1 иргэний өргөдлийг сумын ЕБСургуульд шилжүүлсэн, 3 иргэний өргөдөл шийдвэрлэх шатандаа, 1 иргэний өргөдлийн хариуг амаар мэдэгдсэн болно.

Цэцэг сум:

Засаг даргын Тамгын газар: Сумын Засаг даргын зөвлөлийн 3 дугаар хурал хуралдаж талбайн нээлт, уран нугаралтын хөшөө, шинэ байрны тохижилт үйлчилгээний цогц асуудлын талаар, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Бэлон ХХК-тай хамтран оюутны тэтгэлэг олгох тухай, цаг үеийн бусад асуудал зэрэг асуудлыг хэлэлцлээ.

Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Бэлон ХХК-тай хамтран оюутны тэтгэлэгт 30 сая төгрөгийг шийдвэрлэж 100 оюутныг тэтгэлэгт хамрууллаа.

ХХҮГ: Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийсэн.Зорилтот бүлгийн өрх П.Батмөнхийг сонгож, амьжиргааг нь дэмжих зорилгоор холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, ХХҮГ-т хүргүүлэв.

МЭҮТ: Баруун 5 аймгийн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзүүлэх сургалтанд оролцов. МЭҮТ-т япон мотоцикль хүлээн авлаа.

Сургууль: Шинэ хичээлийн жилийн нээлтээ 9-р сарын 1-нд хийв. Зургаан настай 64 хүүхэд 2 бүлэгт хуваагдан суралцаж байна.

Дотуур байрны сурагчдыг 9 сарын 3-наас эхлэн хуваарилан авсан. Зургаан настай 64 хүүхэд 2 бүлэгт хуваагдан суралцаж байна.

Эрүүл мэндийн төв: Тарваган тахал"өвчний гарын авлага100 хүнд тарааж, Баян овоо багийн иргэдэд 2 удаа сургалт хийж, 38 хүн хамруулав. УБ хотын "Итгэл

хавдаргүй монгол” үндэсний сангийн эмч нар хөх,умайн хүзүүний үзлэг 90 хүнд хийж зөвлөгөө өгч амжилттай ажилласан .

Хүүхдийн хараа хамгаалах өдрөөр сургуулийн 136 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, судалгаа гаргав.

Хүүхдийн цэцэрлэгийн төв: Тус цэцэрлэг нь багш мэргэжлийн ажлын байранд 3 багшийг сонгон шалгаруулж авч ажиллуулж байна. Цэцэрлэг нь Хөшөөт салбартайгаа 7 бүлэгт 200 хүүхдийг хамруулан сургалт хүмүүжлийн ажлаа зохион байгуулж байна.

Чандмань сум:

Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл: Сумын Засаг даргын Тамгын газар нь аппаратын өргөтгөсөн зөвлөгөөнийг зохион байгуулан орон нутагт хийгдэх цаг үеийн болон өвөлжилтийн бэлтгэл ажил хангах талаар асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ.

Аймгийн Засаг даргын албан даалгаврын хадлан тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулан өвөлжилтийн бэлтгэл 50%тай байна.

Иргэний бүртгэл мэдээллийн чиглэлээр: 09 дугаар сард Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд шинээр төрсөн хүүхэд 4, гэрлэлт-4, нас баралт-1, шилжин явсан-2, шилжин ирсэн-1, 25, 45 насны иргэдийн паспортны сунгалт 2 иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Хөдөө аж ахуй: Газар тариалангийн талаар: Сумын дүнгээр 4.8 га газар төмс, 2.6 га газар нарийн ногоо, 1.3 га газар жимс жимсгэнэ тариалж, 1500 тн байгалийн хадлан 300 гаруй тн гар тэжээл 525 тн хужир шүү бэлтгэх сумын аюулгүй нөөцөд өвс 50 тн, тэжээл 30 тн бэлтгэх албан даалгавартайгаас сумын нөөцийг бүрдүүлэх талаар анхаарч 7.5 сая төгрөг шийдвэрлэн бэлтгэх ажилдаа ороод байна. Мөн багуудын фондод баг бүр 3 сая төгрөгийн өвс тэжээл нөөцөлж авсан дүн мэдээтэй байна.

Мал сүргийг эрүүлжүүлэх урьдчилан сэргийлэх хугацаат вакцинжуулалтыг хийх ажлыг графикийн дагуу зохион байгуулан төл малын бруцеллёз өвчний ШТАМ 19 RTV 1 вакцинуудыг 1546 толгой тугал, 36085 толгой хурга, 40512 толгой ишиг нийт 78143 толгой төл малд хийсэн дүн мэдээтэй байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд Амьжиргааг дэмжих зөвлөл 2 удаа хуралдсан. Хуулийн дагуу нийт 704 иргэнд 171914.0 мянган төгрөгийн халамжийн тэтгэвэр, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжинд нийт 66 иргэнд 25344.0, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжинд 118 иргэнд 27100.0, ахмад настны унааны зардалд 18 иргэнд 2730.0, хөгжлийн бэрхшээлтэй иргэний харилцаа холбооны зардал 3 иргэнд 160.0 мянган төгрөгийн тэтгэмж өгч халамжийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үзүүлэн ажиллалаа.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Шимтгэлийн орлого 9627.3, иргэний сайн дурын даатгалд 34 иргэнээс 2595.0, эрүүл мэндийн даатгалд 21 иргэнээс 861.1 нийт 13083.4 мянган төгрөгийн орлого орууллаа. 4 иргэнээс тэтгэвэр тогтоолгох өргөдөл хүлээн авч хувийн хэрэг бүрдүүлж материалыг бүрдүүлэн судлаж байна.

Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 80436.0 мянган төрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврийг 258 хүнд 69769.9 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 12 хүнд 2767.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 33 хүнд 2767.0 мянган төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг тус тус олголоо.

Эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр: Сумын эрүүл мэндийн төв нь 8-9 сард 297 иргэнд амбулаториор үйлчилж, 9 сард 18 иргэнийг хэвтэн эмчлүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Хүүхдийн нүдний эмгэгээс урьдчилан сэргийлэх зорилгоор цэцэрлэгийн хүүхдэд нүдний эмгэгээс сэргийлэх хараа шалгах үзлэг хийж, цэцэрлэгийн 4 бүлгийн 82 хүүхдээс цагаан хорхойн шинжилгээ авч ажиллалаа .

8-9 сард элэгний ВС илрүүлгийн үзлэг шинжилгээнд 82 иргэнийг хамруулж С вирус илэрсэн 12 иргэнийг С вирусын идэвхижил тоолуулах дараагийн арга хэмжээнд хамруулж эрүүлжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Артерийн гипертензи болон чихрийн шижингийн, умайн хүзүү хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт зорилтод насны хүмүүсийг 100 хувь хамруулахаар ажиллаж байна.

Боловсролын үйлчилгээний чиглэлээр: Хичээлийн шинэ жилийн нээлтийг 9 сарын 01-нд зохион байгуулав. 2017-2018 оны хичээлийн жилд шинээр 6 настан 41 сурагч элсэн суралцаж байна.

Сурагчдын сурах бичгийг анги удирдсан багш нараар дамжуулан олгож 1-5 ангийн сурах бичгийн хангалт 98 хувь, дунд, ахлах ангийн сурах бичгийн хангалт 40 хувьтай олгогдсон.

Эрдэнэбүрэн сум:

12 жилийн сургуулийн 2017-2018 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа.

8 сарын 31-нд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийн хэлээлцүүлгийг зохион байгуулж 225 иргэн оролцож, 500 иргэний саналыг авч нэгтгэн хүргүүлэв.

Сумын өвсний аюулгүй нөөцөд 50 тн өвс татаж нөөц бүрдүүллээ. “Цэвэрч Ховдчууд” аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гарган баг, байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна.

125 сая төгрөгийн өртөг бүхий ХААН банкны орчин үеийн барилгыг 9 сарын 25-ны өдөр ашиглалтанд хүлээн авсан байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус 6 дугаар хуралдаан 9 дүгээр сарын 15-ны хуралдаж, 12 жилийн сургуулийн 2016-2017 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилт, хийсэн ажлын тайлан, зарим газрыг орон нутгийн хамгаалалтанд авах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэж, шийдвэр гаргав.

Сумын “Бүтээлч ажлын өдөр”-өөр Засаг даргын Тамгын газрын 80 м орчин үеийн хашааг барьж ашиглалтанд оруулав.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 12 малчинг тус бүр 4 сая төгрөгний буюу 40 ишигтэй ямаагаар малжуулах төсөлд хамрууллаа.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.ГАНБОЛД